

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СЭТГҮҮЛ

НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

**MONGOLIAN  
ECONOMY**

2015 оны 2 сар. №02, 03 (081, 082)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)


АРШАД САЙЕД: “ПИЙБОДИ” КОМПАНИЙН ХУВД  
УРАМ ХУГАРАХААР ШИЙДВЭР БОЛСОН

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨРИЙН ТОЙМ

ПУТИНЫ ТОЛГОЙНЫ ӨВЧИН

# ТАВАНТОЛГОЙН ТӨМӨР ЗАМЫН “НО”

5.6 КМ ТӨМӨР  
ЗАМЫН ГҮҮР НЬ  
МЕГА ТӨСӨЛТЭЙ  
ДҮЙХ БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТ  
БОЛЖ ТААРАХ НЬ



# THE NEXT GENERATION RANGE ROVER

landrover.com



ABOVE AND BEYOND



## The Next Generation Range Rover

Range Rover нь 10 орчим жилд нэг л удаа бүрэн шинэчлэгддэг. 2013 оны загвар нь энэхүү шинэчлэлийн дөрөв дэх үеийн анхны загвар бөгөөд 8 шатлалт автомат хурдны хайрцаг, Гэнэтийн үеийн тоормозны систем, Ухрах хөдөлгөөн мэдрэгч, Зай мэдрэгч систем, Хурд тохируулагч систем, Хелоп их гэрэл, Хаалга зөөлөн хаах систем, Өөрийгөө өндөрлөх систем, Гар хийцийн савхин суудал, Иж бүрэн камерын систем, Энтертайнмент технологийн шийдэл, Гадаргуу мэдрэх технологи, Зогсоолд байршуулах систем, Царс модон халдаг жолооны хүрд, Дээд зэрэглэлийн цэвэр модон эдлэл, Дотоод тансаг гэрэлтүүлэг, Бороо мэдрэгч автомат шил арчигч, Салоны дөрвөн тусдаа температур тохируулагч зэрэг жолооч таны аюулгүй байдал, тав тухыг хангасан технологийн олон давуу талыг өөртөө шингээсэн автомашин юм. 2013 оны Range Rover загварын бүх бие сайжруулсан хөнгөн цагаан материалаар хийгдсэн тул жин нь 400 гаруй килограммаар багасч бусад автомашинтай харьцуулахад цохилтын хүчийг хоёр дахин өөртөө шингээж ослын үед жолооч, зорчигчдыг бэртэл гэмтлээс хамгаалах маш том давуу тал болсон аж.

## Вагнер Ази Автомотив ХХК

Нарны зам 55/1, Тээвэрчдийн гудамж, Сүхбаатар дүүрэг, 14253, Монгол улс

Утас/Факс: 976-70113673, 99108368, 99108386, 99118301, 99118375

[www.waa.mn](http://www.waa.mn)



[www.facebook.com/landrovermn](http://www.facebook.com/landrovermn)

**Хөдөлгүүр:** 4400 cc, Turbo Diesel V8; **Шатахуун зарцуулалт:** Хотод: 14-17 литр, Шулуун замд: 9-11 литр, Дунджаар: 12-14 литр дизель;  
**Хөдөлгүүр:** 5000cc Supercharged V8; **Шатахуун зарцуулалт:** Хотод: 22-25 литр, Шулуун замд: 13-16 литр, Дунджаар: 18-21 литр бензин.

GOBI

MONGOLIAN CASHMERE

# ҮЗЭМЖ ТӨГӨЛДӨР ҮЛЭМЖИЙН ТАНСАГ

*Сар шинийн загварууд  
худалдаанд гарлаа*

Ногоон хөгжлийн төлөө



Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:  
Д.Бэхбаяр / 9999-4248  
Үүсгэн байгуулагч, Орлогч Эрхлэгч:  
И.Отгонжаргал / 8800-6228  
СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:  
Б.Үүрийнтуяа  
Англи хэлний редактор:  
Ийланд Роберт Мэнн  
ВЭБ РЕДАКТОР:  
Б.Энхцэцэг  
Сэтгүүлчид:  
Б.Баяртогтох  
Э.Зоригт  
А.Бүрэнжаргал  
Дизайнер:  
Ц.Энхтүвшин

Маркетингийн менежер:  
Д.Барянжав / 9409 2904  
Б.Наранцогт / 9409 2905

#### ХАЯГ

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,  
VI хороо, Их сургуулийн гудамж,  
AB center. 504 тоот  
15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762  
www.mongolianeconomy.mn  
info@mongolianeconomy.mn  
Утас/Факс: 976 - 7011 5476  
“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв  
www.ubprint.mn

#### Борлуулах цэгүүд:

“Интер ном”  
“Цэцэг төв”  
“Минж плаза”  
“Алтантүлхүүр” номын дэлгүүр  
“Номин” супермаркетиin бүх салбар  
“Макс” супермаркетиin бүх салбар  
“Фреско” супермаркет  
BTSI супермаркет  
“Аз орчлон” номын дэлгүүр  
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг  
“Гранд Плаза” дахь супермаркет  
“Мир” номын дэлгүүрийн  
“Grand plaza”  
“Metro mall”  
“Sky” супермаркет  
“Улаанбаатар” их дэлгүүр  
“Max mall” дэх салбарууд

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн “2013  
оны Шилдэг сэтгүүл”

Монголын бизнесийн зөвлөлийн  
“Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл  
мэдээллийн байгууллага - 2012”  
МҮХАУТ-ын “2011 Оны Онцлох Хэвлэл”



РЕДАКЦИА  
ЗАХИАЛБАЛ  
ХҮРГЭЛТ  
ҮНЭГҮЙ

## БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ

# 18.000₮

## ЗАХИАЛГЫН ҮНЭ

НЭГ ДУГААР	15.000₮
УЛИРАЛ /6 дугаар/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 дугаар/	180.000₮
ЖИЛ /24 дугаар/	360.000₮



**ЭДИЙН ЗАСАГ**

- ..... 8 Цогц түншлэлийн “цоохор” түнш

**ОНЦЛОХ**

- 10 Тавантолгой улс төрийн дэмжлэг авахгүй бол унана



- 12 Дахиад нэг мега төсөл
- ..... 13 Аршад Сайед: “Пийбоди” компанийн хувьд урам хугарахаар шийдвэр болсон
- 16 М.Энхсайхан: “Пийбоди” хөрөнгө оруулалт хийе гэсэн амлалт өгөөгүй
- 18 1072 хувьцааг амилуулснаар ямар ашиг хүртэх боломжтой вэ



**БИЗНЕС**

- 20 Шинэ хандлага
- 23 Удирдлагуудын гаргадаг таван том алдаа
- 26 Жаксон Кокс: 2015 он шийдлийн жил байгаасай

**БОДЛОГЫН СУДАЛГАА**

- 28 Засгийн газрын гадаад өрийн тойм

**ЕРТӨНЦ**

- ..... 34 Давосын өртөг
- 35 ОХУ-ын хямралтай жил
- ..... 36 Путины толгойны өвчин

**УУЛ УУРХАЙ**

- 37 Монголыг тэтгэгч ЗЭС, НҮҮРС, ГАЗРЫН ТОС
- 40 Б.Сайнбаяр: “Рио Тинто”-гийн алдааг дэлхий шүүхээс Монгол шүүж дийлэхгүй

Манай сайт руу зочилж, өдөр бүр эдийн засаг, бизнесийн талаар шинэ мэдээлэл аваарай.

**ЭДИЙН ЗАСАГЧДЫН БУЛАН**

MongolianEconomy.mn/ дээр доорх **улаанаар тодруулсан** тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.



**Б.Эрдэнэбат**

**Мэдлэг бол хүч ба Өвөр Монголоос төрсөн сэтгэгдэл**

Өвөр Монголын дөрвөн том их сургуульд очиж урилгаар лекц уншив. Сайхан монголчуудтай танилцлаа. Монгол улсад Солонгосын соёлын нөлөө их болж байгаа. Харин Өвөр Монголд Монгол улсын маш их байдаг юм байна. Бидний уран зохиол, урлаг - [mn/p/7176](#)



**Т.Ганзориг**

**Хөшүүрэг**

Хүний үйл хөдлөлийг удирддаг Эдийн засгийн ба Философийн хөшүүргүүдийг өнөөдөр авч үзье. Нэг талдаа Хүн буруу зүйлд амархан уруу татагддаг, залхуу, амин хувиа хичээсэн, аймхай амьтан. Гэхдээ хүнийг эдгээр зан чанарууд нь нээлт хийлгэж - [mn/p/7268](#)




**Б.Дөлгөөн**

**Хямралын гарц бол экспорт**

2015 оны босгон дээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн үгэндээ Монголын эдийн засаг хямарлаа гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Эдийн засгийн тодорхойлолтын хувьд хоёр улирал дараалан эдийн засаг агшихыг хямрал гэж нэрлэдэг. Гэтэл 2014 оны арваннэгдүгээр сарын байдлаар - [mn/b/7292](#)

## Уул уурхай



Оюутолгойн асуудлаар “Rio Tinto” групптэй хийх Монгол Улсын Засгийн газрын хэлэлцээрийн хүрээнд хөрөнгө оруулагч тал хайлуулах үйлдвэрээс хоёр хувийн роялтийн төлбөр авах байснаас татгалзсан. ОУВС-гаас гаргасан тооцоогоор Монгол Улс татварын өмнөх ашгийн 55-71 хувийг авах аж. Далд уурхайн үйл ажиллагаа эхлэхэд одоогоор хийгдсэн 500 сая ам.долларын бүтээн байгуулалтаас гадна 4.9 тэрбум ам.доллар шаардлагатай байгаа юм.

## Аж үйлдвэр



Төрөөс аж үйлдвэрийн салбарт 2030 он хүртэл баримтлах бодлогыг гурван үе шаттай хэрэгжүүлэхээр болжээ. Энэ хүрээнд аж үйлдвэрийн бүсийн хөгжлийг тодорхойлон “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулахаар төлөвлөөд байна.

Түүнчлэн үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр,

логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх, худалдааны таатай орчин бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх зэрэг ажил багтсан.

## Эрчим хүч



Монгол Улс 2020 он гэхэд нийт эрчим хүчнийхээ 20 хувийг сэргээгдэх эх үүсвэрээс бий болгох боломжтойг Сэргээгдэх эрчим хүчний зургаадугаар форумын үеэр салбарын мэргэжилтнүүд хэлсэн. Ингэснээр агаарын бохирдол буурах, байгаль орчинд нөлөөлөх сөрөг үзэгдэл багасах, мөн үнийн хувьд хямд байх боломжтой аж. Өнөөдрийн байдлаар манай улс нийт эрчим хүчнийхээ найман хувийг сэргээгдэх эх үүсвэрээс гаргаж байна. Төрийн бодлогоор дэмжих, сэргээгдэх эрчим хүчний техник технологид татварын хөнгөлөлт үзүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдаалж буй тохиолдолд ашгийн татвараас чөлөөлөх зэргээр цаашдын хөгжлийг дэмжих боломж байгаа аж.

## Үл хөдлөх

Өнгөрсөн онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийт 13523 иргэн газартай болсон. Харин он гарсаар газар өмчлөх хоёрдугаар ээлжийн бүртгэл хоёрдугаар сарын



9-ийг дуустал 13819 нэгж талбайд үргэлжлэх аж. Бүртгүүлэхдээ Нийслэлийн өмчийн харилцааны газрын [www.umch.ub.gov.mn](http://www.umch.ub.gov.mn) хаягаар хандах юм. Энэ удаа нийт 13823 иргэнд газар өмчлүүлнэ.

## Даатгал



Нийгмийн даатгалын төлбөрийн мэдээллээ цахимаар хянах боломжтой болжээ. Ингэхдээ Нийгмийн даатгалын ерөнхий газрын [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) цахим хуудсын “Даатгуулагчийн цахим мэдээлэл” хэсэгт бүртгүүлэн мэдээллээ шалгаж болох аж. Өнөөгийн байдлаар сайн дурын даатгалд даатгуулагчид 160 орчим мянга, албан журмын даатгалд даатгуулагчид 850 орчим мянга байгаагийн дийлэнх нь залуус байна. Нийгмийн даатгалын дэвтэр нь даатгалаас гадна банкны үйлчилгээ авах, гадаад улс оронд зорчих виз хүсэхэд тухайн хүний орлогыг тодорхойлох баталгаа болгон ашиглах тохиолдол их байдаг.

## Дэлхийн мэдээ

## Грекийн сонгууль



Зүүний гэгдэх Сириза нам ялалт байгуулсан нь тус улсын иргэд евробүс болон Олон улсын валютын сангаас хэрэгжүүлж буй эдийн засгийн хатуу бодлогыг дэмжихгүй байгаагаа илэрхийлсэн явдал боллоо. Тус улсын нийт өр 370 тэрбум ам.долларт хүрсэн төдийгүй ирэх гуравдугаар сард төлж барагдуулах үүрэгтэй. Гэсэн ч энэ богино хугацаанд өрийг барагдуулах боломжгүй гэдгийг эрх баригчид хэлж буй. Эдийн засаг нь агшисаар буй Грек улсад ажилгүйдлийн түвшин 26 хувьд хүрсэн бөгөөд ядуу иргэдийн тоо нэмэгдсээр байгааг олон улсын судалгааны байгууллагууд мэдээлж байна.

## Оросын зэрэглэл



“Standard & Poor’s” Оросын зээлжих зэрэглэлийг “BB+” болгон бууруулсан нь өнгөрсөн 10 жилд байгаагүй муу мэдээ боллоо. Тус байгууллага ОХУ-ын эдийн

засгийн өсөлтөө дэмжих мөнгөний бодлогын хөрвөх чадвар муу гэж үзжээ. Өнгөрсөн долоон сарын хугацаанд рублийн ханш 51 хувиар суларч, улмаар инфляци огцом өсөж буй нь тус улсын эдийн засгийн өсөлтийг чөдөрлөсөөр байгаа юм. ОХУ-ын эдийн засаг газрын тосны орлогоос шууд хамааралтай. Түүнчлэн барууны орнуудын хориг арга хэмжээ үргэлжлэхээр байгаа нь тус улсын эдийн засаг улам хүндрэнэ гэсэн хүлээлт үүсгэж байна.

### Сингапурын үл хөдлөх



Тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын өсөлт 2014 онд дөрвөн хувиар унасан. Энэ нь Сингапурт ажиллаж, амьдарч буй гадаадын иргэдийн тоо буурч байгаа, тэдэнд ногдуулах татварын хэмжээ нэмэгдсэн, мөн Засгийн газрын зүгээс дотоодын иргэдийн орон сууц худалдан авах зээлийн нөхцлийг өөрчилсөнтэй

холбоотой аж. Түүнчлэн орон сууцны нийлүүлэлт эрэлтээ давсан нь ханшийн уналтад нөлөөлж буй. Улмаар орон сууцны ханш цаашид улам унах төлөвтэй байгаа юм.

### АНУ, Энэтхэгийн түншлэл



Ази тивд нөлөөлөх бусад орны нөлөөг тэнцвэржүүлэх асуудлаар АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама Энэтхэгийн Ерөнхий сайд Наренда Модии нар өнгөрсөн сард уулзсан. Тэд дэлхийн эдийн засаг болоод бусад стратегийн асуудлаар ярилцахдаа бүс дэх Хятадын нөлөөг багасгах, мөн тус улсын батлан хамгаалахын үйл ажиллагаа идэвхтэй болж буй талаар хэлэлцэв. Хэдийгээр Энэтхэг улс ямар нэг оронтой холбоотон биш ч сүүлийн саруудад АНУ-тай харилцаагаа сэргээж буй. АНУ-д гурван сая орчим Энэтхэг гаралтай иргэн оршин суудаг нь хоёр орны харилцааг ахисан түвшинд хүргэх хангалттай нөхцөл хэмээн хоёр орны төрийн тэргүүд үзэж байна.



## # МОНГОЛ ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

Cover Mongolia @CoverMongolia Jan 20

#Монголын худалдааны тойм 2014: Худалдааны ашиг 537.9 сая ам.доллар, Экспорт +35.3%, Импорт -17.6% / Нэгдүгээр сарын 19

[www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2014/201412e.pdf](http://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2014/201412e.pdf)

Төвбанкны оны эцсийн гадаад худалдааны тойм экспорт өсч, импорт буурснаас үүдэн нийт худалдааны тэнцэл 126 хувиар сайжирсан гэв. Уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 89 хувийг эзэлж байна. Зэсийн баяжмалын экспорт 171 хувиар өссөн бол коксжих нүүрс болох төмрийн хүдрийнх буурчээ. Үйлдвэрлэлийн машин, техник технологи болон өдөр тутмын хэрэглээний суудлын машин оруулж ирэх нь багассанаас үүдэн нийт импорт буурсан байна. Түлшний импорт мөн буурсан бол барилгын материалын импортын хэмжээ 2013 оныхтой ижил байжээ. Худалдаа ашигтай гарсан нь Монгол төгрөгийн ханшийг тогтворжуулахад нэмэр болох учиртай.

Thomas Eriksson @ThomasE\_UNDP Jan 19

@RobertAlanWard#Mongolia нь улс төрийн соёл, оролцооны түвшний хувьд 6.62 оноо авч 61 дүгээр байрт жагссан нь ардчиллын хувьд бүрэн бус, согогтой гэх ангилалд багтаж байна. by #eiudemocracy

The Economist сэтгүүлийн дэргэдэх "Economics Intelligence Unit" судалгааны байгууллага Монгол ардчиллын хувьд хүртээмжгүй, дутагдалтай орон хэмээн манай улсад хийсэн судалгаагаараа дүгнэжээ. Ардчиллын индекс сонгуулийн үйл явц ба олон ургалч үзэл, иргэний эрх, засгийн газрын үйл ажиллагаа, улс төрийн оролцоо ба улс төрийн соёл гэсэн таван ангилалд суурилсан. Монголын хувьд сонгуулийн үйл явц, олон ургалч үзэл болон иргэний эрх чөлөө гэсэн ангилалд өндөр үнэлгээ авсан бол Засгийн газрын үйл ажиллагаа, улс төрийн соёл, оролцоо талаас тааруу оноо авчээ. Монгол нь бүс нутагтаа ардчиллын хувьд хүртээмжгүй дутагдалтай гэх 10 орны нэгт багтсан бөгөөд дэлхийн 165 орноос 61 дүгээрт оржээ.

Halifax@HFXforum Jan 19

Хөрөнгийн эрэл хайгуулд, #Mongolia газар нутгийн тавны нэгийг уул уурхайн зорилгоор ашиглуулахаар үүцээ задлалаа

<http://www.reuters.com/article/2015/01/16/mongolia-mining-idUSL3N0UV2AH20150116>

Монголын Засгийн газар хайгуулын лиценз олгож эхэлсэн бөгөөд өмнөх 10.1 сая га талбай гэх хязгаараа 30.8 сая га талбай болгон уул уурхайн салбарынханд боломж олгож эхэллээ. Энэхүү талбай нь нийт нутаг дэвсгэрийн тавны нэгтэй тэнцэх юм



Твиттер дээр биднийг дагаарай  
[twitter.com/EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)



Фэйсбүүк дээр бидэнтэй нэгдээрэй  
[Facebook.com/Mongolian.Economy](https://Facebook.com/Mongolian.Economy)

Онлайн захиалга өгөхдөө  
<http://goo.gl/KV50W>  
линкээр орох буюу энэ кодыг  
сканнердаарай:





## Цогц түншлэлийн “цоохор” түнш

Б.Энхцэцэг

Бид өнөөдөр япончуудын хандивласан тээврийн хэрэгсэл, зам, гүүрийг ашиглаж, хүүхдүүд маань тэдний барьж өгсөн сургуульд сурч байгаа. Энэ бол япончуудын бидэнд буцалтгүй болон хөнгөлөлттэй олгосон хандив, тусламжаас олон түмний зөвхөн нүдэнд үзэгдэж, гарт баригдаж буй цөөн хэдэн жишээ. Тэд бидэнд чамгүй ихийг өгч, бид тэдний өгөөмөр гарыг зовох цагт олонтаа харсан. Харин өнөөдөр япончууд Монголын эдийн засгийг тусламжийн түвшнээс түншлэлийн зэрэгт хүрсэн хэмээн үнэлж, эдийн засгийн ижил зиндаанд харилцахаар болж буй.

Үүний илрэл нь 10 жилийн хугацаатай хийгдэж буй хоёр орны Эдийн засгийн түншлэлийн гэрээ. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд хоёр тал чөлөөт худалдааны зохицуулалтуудыг хэрхэн хийх талаар хэлэлцсэний дүнд гэрээг энэ оны хоёрдугаар сарын дундуур үзэглэн баталгаажуулах гэж байна.

Манай улсын нийт эдийн засгийн хэмжээ Япон улсын 4.2 их наяд ам.доллараар илэрхийлэгдэх ДНБ-ий нэг хувьд ч хүрэхгүй өчүүхэн. Зах зээлийн боломжийн хувьд ч 130 сая хүн амтай энэ том гүрэнд манай улстай чөлөөт худалдааны нэг хаалгатай болно гэдэг төдийлэн ашигтай хувилбар биш нь мэдээж. Бид Япон улсын хувьд

худалдааны чөлөөт гэрээ байгуулж буй 15 дахь улс нь.

Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан бусад улсын жишгээс харахад хэлэлцээр байгуулснаас хойш хоёр орны хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээ нэлээд хэмжээгээр өссөн байгааг Ж.Отгонсайханы “Япон улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад анхаарч үзэх зарим асуудал” судалгаанаас харж болохоор байна. Тухайлбал, судалгаанд дурьдсанаар бол Япон Мексик нь 2005 онд энэ төрлийн хэлэлцээрийг байгуулсан бөгөөд Мексикээс Япон руу экспортлосон барааны хэмжээ 22.3 хувь, Японоос Мексик руу экспортлосон барааны хэмжээ 44.9 хувиар өсчээ. Түүнчлэн мөн онд Мексик улсын нийт гадаадын шууд хөрөнгө оруулалт 3.31 тэрбум ам.доллар байсан бол 2006 онд 9.09 тэрбум болж гурав дахин нэмэгдэж. Үүний дотор Япон улсаас оруулсан хөрөнгийн хэмжээ 242 хувиар өсчээ. Хөрөнгө оруулалтын ихэнх нь автомашин үйлдвэрлэх салбарт орсон бөгөөд Мексик улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын 37 хувийг АНУ, 13 хувийг Канад, 10 хувийг Японоос оруулсан хөрөнгө оруулалт бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр орнууд нь бүгд

Мексик улстай чөлөөт худалдааны хэлэлцээртэй.

Монгол Улсын Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх О.Чулуунбат “Монголын хувьд Японтой өрсөлдөөд байхаар зах зээлтэй биш учир тус улсын ямар ч үйлдвэр манайхаас айхгүй. Нөгөө талаас бидэнд тэднээс айгаад байх зүйлгүй. Тиймээс манай хоёр орон эдийн засгийн хувьд зөрчилгүй орнууд” гэсэн юм. Бид яаж ч хичээгээд Японы эдийн засагт нөлөөлөхүйц хүч байх боломжгүй ч манай улсын хувьд Азийн барын нөмөр, нөөлөгт орж дараагийн Азийн бар болох арга замыг заалгах гэж байгаа нь завшаан.

Одоогийн байдлаар Монгол Улс импортын дийлэнх бараанд нэгэн жигд таван хувийн гаалийн татвар ногдуулдаг. Монголд суугаа Японы Элчин сайдын яамны холбогдох албаныхан Эдийн засгийн түшлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор хоёр орны эдийн засагт ямар нөлөө үзүүлэх талаар тодорхой тоо, хэмжээгээр илэрхийлэхэд хүндрэлтэй байгааг хэлсэн. Мөн тэдний зүгээс “Япон улсаас Монгол руу гаалийн татваргүй гаргадаг экспортын бүтээгдэхүүн нь одоогийн байдлаар экспортын нэг хувьд ч хүрэхгүй хэмжээтэй байгаа. Хэлэлцээр хүчин төгөлдөр болмогц энэ

тоо ойролцоогоор 50 хувь, 10 жилийн дотор 96 орчим хувь болж нэмэгдэнэ” гэсэн тооцоо байгаа гэв.

Манай хоёр улс 2013 онд нийт 454 сая ам.долларын худалдаа хийснээс экспорт 10 сая, импорт 444 сая ам.доллар байв. Япон Улстай хийсэн нийт худалдааны хэмжээ БНХАУ, ОХУ, БНСУ, АНУ-ын дараа тавдугаарт орж байна.

Манай улсын Японоос импортлодог голлох бүтээгдэхүүн бол хуучин машин. Монгол Улс 2013 онд нийт 372 сая 982 мянган ам.долларын суудлын автомашин импортлосноос 77,9 хувийг нь Япон Улсаас оруулж иржээ. Худалдааны алдагдлын хувьд урьдын адил өндөр байна.

Ирэх 10 жилд багтаан Япон улсын Монголоос хийж буй импортыг 100 хувь гаалийн татвараас чөлөөлөх бөгөөд Монгол Улсын уул уурхай болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ихэнх нэр төрлийн тухайд хэлэлцээр хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн үе шаттайгаар гаалийн татвараас бүрэн чөлөөлөхөөр тохиролцсон аж. Үүнээс гадна Монголын талаас хүсэлт тавьсан нэр төрөл болох боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүн болон тэжээвэр амьтны хоол зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд тодорхой хөнгөлөлт үзүүлэх юм байна. МУ-ын Ерөнхий сайдын зөвлөх О.Чулуунбат “Японы бусад улстай байгуулсан чөлөөт худалдааны гэрээг харахад гэрээ байгуулсны дараах жилүүдээс хөрөнгө оруулалт хэд дахин нэмэгдэж, худалдаа нь 5-10 дахин өссөн түүх байдаг” гэсэн юм. Нөгөө талаас Монголын хувьд ирэх жилүүдэд хамгийн өндөр ашиг хүртэх боломжтой нь ноос, ноолуурын салбар, харин Японы хувьд Монгол руу экспортлох машины тоо өснө гэж Маса Игата үзэж байна.

Энэ гэрээг байгуулснаар бид үндсэндээ 130 гаруй сая хүн амтай, төлбөрийн өндөр чадамжтай зах зээл рүү ямар ч татваргүйгээр бараа,

бүтээгдэхүүнээ оруулах эрхтэй болж байгаа. Ирэх 10 жилийн хугацаанд хоёр зах зээлээ тохируулж, татвараа тэг орчин руу чиглүүлснээр татваргүй нэг зах зээл болно. Хэдий ийм ч манай үйлдвэрүүд Японы зах зээлийн чанар, стандартыг хангаж бүтээгдэхүүнээ гаргаад байж чадахгүй. Одоохондоо.

Гэрээний дагуу япончууд Монголд ирж техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд манай улсын аль салбаруудад хөрөнгө оруулбал өрсөлдөх чадвартай байхыг судалж, ямар бүтээгдэхүүнийг хэрхэн бага зардалтайгаар үйлдвэрлэлд оруулах, улмаар Японы өргөн сүлжээ бүхий үйлдвэрлэлтэй холбож болох тухай судалгаа хийнэ. Үүний дараа хөрөнгө оруулалт дагаж орж ирнэ хэмээн мэргэжилтнүүд тооцож. Харин хөрөнгө оруулалт хийгээд эхэлсний дараа Японы стандартад нийцсэн бүтээгдэхүүнүүд гарч ирэх юм. Манай бараа, бүтээгдэхүүнийг улсынхаа хилээр оруулахыг зөвшөөрсөн ч бид Япон болон бусад улсын ижил төрлийн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй мөн л зах зээлийн жамаар өрсөлдөж,

шилэгдэж гарч ирэх ёстой.

“Токио Мицүбиши Юу Эф Жэй” банкны төлөөлөгчийн газрын дарга Наоки Хисада “Япон компаниудын хувьд бизнес эрхлэх боломж өндөр Монголын дөрвөн салбар байна” гэж тооцжээ. Үүнд барилга, хөдөө аж ахуй, авто машины худалдаа, агаарын бохирдлыг арилгахад чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа орж байгаа аж. Эдгээр нь Японы компаниудын хүчин чадал, технологи, хөрөнгө санхүүжилтэд бүрэн найдаж болохоор салбар гэж тэрбээр үзэж байгаа юм. Гэвч Японы зах зээл манай талаас зөв маркетинг, тогтвортой өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэлийг шаардаж байгаа. “Японы хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтын тогтвортой орчин бүрдүүлж, мөн хөрөнгө оруулагчдын хөрөнгийг улам сайн хамгаална” хэмээн найдаж байгааг Монголд суугаа Японы Элчин сайдын яамны холбогдох албаныхан хэлсэн юм.

О.Чулуунбат зөвлөхийн хэлж буйгаар хэрвээ бид хурд, хүч сайтай ажиллаж чадвал ойрын таван жилийн хугацаанд ч зарим бүтээгдэхүүнээ Япон руу экспортлоод эхлэх боломж байгаа аж. Цаашлаад Японы зах зээлд хүлээн зөвшөөрөгдчихсөн байхад дэлхийн хаана ч хүлээн зөвшөөрөгдөнө гэв.

Эдийн засгийн түншлэлийн гэрээний гол зорилго нь хоёр улсын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх явдал. Гэхдээ япончууд хөрөнгө ихтэй ч салхинд хийсгээд байх илүүдээ гарсан мөнгөтэй улс биш. Түншлэлийн дагуу энэ удаад тэд бидэнтэй эрх ашгаа тэнцүүлж, эн зэрэгцэн харьцана. Гэрээ байгууллаа гээд баруун, солгойгүй хөрөнгө мөнгө Монгол руу урсан орж ирээд, манай үйлдвэрүүд бараагаа гаргаад эхлэхгүй. Тэгэхийн тулд монголчуудад давах даваа олон, туулах зам урт байна. Бид тэдний хувьд дутагдал ихтэй “цоохор” түнш ч тэд бидний хувьд цогц боломж.





Мега төсөл

## Тавантолгой улс төрийн дэмжлэг авахгүй бол унана

Б.Баяртогтох

Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулахаар шалгарсан БНХАУ-ын “Шинхуа Энержи” компани 13 тэрбум ам.долларын зээлтэй. Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй тус компанийн зах зээлийн үнэлгээ нь 60 тэрбум ам.доллар. “Шинхуа Энержи” компани 2005 онд Хонконгийн Хөрөнгийн бирж, 2007 онд Шанхайн Хөрөнгийн биржид тус тус хувьцаагаа гаргасан байдаг. Харин Японы “Сумитомо” корпораци 41 тэрбум ам.долларын зээлтэй бол “Энержи Ресурс” 900 сая ам.долларын зээлтэй. Хамтарсан түншлэл байгуулж шалгарсан дээрх гурван компани хэлэлцээрт амжилт олбол төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой”-н менежментийг удирдан залах юм.

Монгол Улсын Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн 2013 оны аравдугаар сарын 22-26 нд урд хөршид хийсэн айлчлалын үеэр “Шинхуа Энержи” компанид 20 жилийн хугацаанд нэг тэрбум тонн нүүрс нийлүүлэхээр тохиролцсон. “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьд Хятадын “Чалко”

компаниас авсан 350 сая ам.доллараас 143 сая ам.долларын өр үлдээд байгаа. Бусад газраас авсан зээлийг оруулан тооцвол төрийн өмчит тус компани 845 тэрбум төгрөгийн өртэй болохыг Үндэсний аудитын газраас тогтоосон.

Бэлэн мөнгөний чадвар нь 10 тэрбум ам.доллараар хэмжигдэх “Шинхуа Энержи”-д “Эрдэнэс Тавантолгой” компани 2014 оны дунд үеэс нүүрсээ хэлэлцээрийн дагуу зарж, худалдааны түншүүд болсон. БНХАУ-ын дарга Си Зиньпинтэй уулзсан өмнөх Ерөнхий сайдын айлчлалын томоохон үр дүн нь дээрх яриа хэлэлцээр байсныг тухайн үед талууд онцлон тэмдэглэж байв. 6.2 тэрбум тонн нүүрсний нөөцтэй Тавантолгойн орд бол төрийн өмч. Төрийн өмнөөс лиценз эзэмшиж буй бүрэн эрхтэй компани нь “Эрдэнэс Тавантолгой”. Тиймээс лиценз уг компанийн нэр дээр хэвээр үлдэх юм. Харин “Шинхуа Энержи” Монголын нүүрсний зах зээлийг атгах барьцаагаа улам лавшруулах нь. Манайх нэг тонн сайн чанарын коксжих нүүрсээ 48.5 ам.доллараар “Шинхуа Энержи”-д

нийлүүлж, борлуулалтын орлогоороо “Чалко” компанид төлөх өрөө барагдуулах болсон.

Тавантолгойн ордод олборлолт явуулж буй “Энержи Ресурс”, “Тавантолгой”, “Эрдэнэс Тавантолгой” компаниуд “Шинхуа Энержи” компанийн гэрээт нийлүүлэгч. Өөрийн гэсэн үйлдвэр, төмөр замын сүлжээтэй, томоохон зах зээлтэй “Шинхуа Энержи”-ээс өрсөлдөгчид нь эмээдэг. Тиймээс нүүрсний үнэ тартагтаа тулсан ч тэд бусдад, тэр тусмаа Монголд хөрөнгө оруулах хэмжээнд байгааг гайхах хэрэггүй болов уу. “Шинхуа Энержи” компанийн ар нь БНХАУ. Энэ нь тус компани хэзээ ч дампуурахгүй гэсэн баталгаа болж өгдөг. Тиймээс Монголын нүүрсний зах зээлийг удирдах болсон “Шинхуа Энержи” компанийн зах зээлийн үнэлгээ өндөр байдаг нь үүнтэй холбоотой. Тус компанийг 2004 онд Хятадын төрийн өмчит “Шинхуа” групп үүсгэн байгуулсан.

Дэлхийн нүүрсний зах зээлийн төв цэг нь өмнөд хөрш. Хятадын нүүрсний зах зээлийн томоохон тоглогч нь “Шинхуа Энержи”. Монголын нүүрс экспортлогчдыг төлөөлж “Эрдэнэс Тавантолгой” компани “Шинхуа Энержи” компанитай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Үүний хүрээнд олборлолт, үйлдвэрлэлийн хүчин чадалтай уялдуулан төлөвлөгөө гаргах, олон улсын зах зээлд худалдаалах боломжийг хамтран судлахаар болж байсан. Ингэснээр 20 жилийн хугацаанд Тавантолгойн бүлэг ордоос олборлох нүүрсийг тээвэр, ложистикийн болон зах зээлийн өргөн боломж, нүүрсээ арилжаалах аятай нөхцөл бүрдэж байгааг Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг хэлж байсан удаатай.

Тавантолгойн ордод хөрөнгө оруулах, Монголын “Энержи Ресурс” компанитай түншлэл байгуулах үүдийг манай Засгийн газар хоёр орны улс төрийн яриа хэлэлцээний түвшинд бараг хоёр жилийн өмнө нээж өгсөн гэж болно. Зөвхөн “Шинхуа Энержи”-д Монголын “Эрдэнэс Тавантолгой” тэргүүтэй компаниуд нүүрсээ нийлүүлэх сонголтыг хуучин Засгийн газар нэг удаагийн айлчлалаар шийдчихсэн.

Айлчлалын дараагаас Тавантолгойн ордод хөрөнгө оруулалт хийх


уралдаант шалгаруулалт зохион байгуулах ажил эрчээ авч, Засгийн газрын “хуучин” тогтоолууд амилж эхэлсэн юм. Ингэснээр Тавантолгойн нүүрсний ордод “Хөрөнгө оруулж, хамтран ажиллах гэрээ” байгуулах хэлэлцэрийн талбарт гурван улсын хамтарсан нэгдэл тодорч, хэлэлцээр үргэлжилсээр хоёр дахь шатанд шилжээд байна. Дэлхийд нүүрсний эрчим хүчний үйлдвэрлэлээр тэргүүлж буй “Шинхуа Энержи” нь өөрийн эзэмшдэг таван төмөр замаар нийт тээвэрлэлтийнхээ 60 гаруй хувийг хийдэг. Тус компани нүүрсний үйлдвэрлэл, худалдаа, төмөр зам, эрчим хүчний чиглэлээр дагнаж ажиллаж байна. Хэлэлцээр амжилтад хүрвэл Тавантолгойн нүүрс Орос болон Мозамбикийн нүүрсний мега төслүүдтэй өрсөлдөхүйц байж л зах зээлд байр сууриа олох юм. Тиймээс цаг хугацаа хэмнэх шаардлага байгааг хоёр талаас мэдэгдээд буй.

Тавантолгойг шавдуулан зүтгүүлэх нь зах зээлийн өрсөлдөөн ширүүсч байгаатай холбоотой. Орд нь газрын гадаргад ойр байрласан, ил аргаар олборлох бололцоотой. Энэ нь Тавантолгойн давуу тал. Харин дэд бүтэц хөгжөөгүй, хөрөнгө оруулалт их хэмжээгээр шаардлагатай байгаа нь сул тал болоод байгаа. Монгол Улсын мега төслийг хариуцсан сайд нь М.Энхсайхан. “Шийдлийн” хэмээх тодотголтой шинэхэн Засгийн газарт түүний үүрэг оролцоо их. Тавантолгойн хэлэлцээр биеллээ олж, үр дүнд хүрвэл дотоодын нүүрсний салбарт сэргэлт гарч, Тавантолгойн ордын өгөөж нэмэгдэх төдийгүй төмөр замын бүтээн байгуулалт урагшилна. Хэлэлцээрийн стратеги нь харилцан ашигтай байх. Энэ бол зарчим төдийгүй дүрэм. Үүний хүрээнд л асуудлыг талууд шийдэх юм.

Дэлхийд хэрэгжүүлэхээр ярьж байгаа гурван мега төсөл тутмын нэг нь амжилт олдог байна. Энэ утгаараа мега төсөл шил мэт эмзэг. Тиймээс болгоомжтой, шинжлэх ухааны үндэслэлтэй хандах учиртайг Тавантолгойн хэлэлцээрийн ажлын хэсгийг ахлагч, сайд М.Энхсайхан тэмдэглэсэн. Мега төслийг дангаараа


### Дэлхийн нүүрсний батлагдсан нөөц

Монголын нүүрсний нөөцийн эзлэх хувь 2% байна




### Дэлхийн түүхий ган үйлдвэрлэл

Дэлхийн гангийн үйлдвэрлэл - 2000 он 849 сая тонн



Дэлхийн гангийн үйлдвэрлэл - 2010 он 1.42 тэрбум тонн



2011 онд, Хятад улсын түүхий гангийн үйлдвэрлэл нийт дэлхийн үйлдвэрлэлийн 44.3%-ийг эзэлжээ.

санхүүжүүлэх нэг ч орон, нэг ч компани байхгүй аж. Энэ нь хөрөнгө оруулалтын хэмжээ дэндүү их, эрсдэл асар өндөр байдагтай холбоотой гэнэ.

Банк, санхүүгийн байгууллагууд тухайн

төслийг санхүүжүүлэхийн тулд төслийн компаниас тусгай зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Тэгвэл Тавантолгой хэмээх мега төслийн хүндрэл нь тусгай зөвшөөрөл болж магадгүй нь. Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулалт хийх хэлэлцээрийн өмнө тусгай зөвшөөрөл гэсэн “хана” бий. Түүнийг шилжүүлэх эрх нь УИХ-ын гишүүдэд байгаа. Өөрөөр хэлбэл, Тавантолгойн хэлэлцээр төрийн дэмжлэггүй бол цааш явахад улам хэцүү болох талтай. Төр, хувийн хэвшлийн түншлэл байж гэмээнэ мега төсөл бүтдэг аж. Тавантолгойн хөрөнгө оруулагчийг тодруулах уралдаант шалгаруулалт таван “настай”. Ирэх жил сургуульд орох насандаа хүрнэ гэсэн үг. Сургууль нь дэлхийн өрсөлдөөнт зах зээл юм.

“Тавантолгой” төслийн менежмент “Эрдэнэс толгой”-оос “Энержи Ресурс”-т шилжих явц хэлэлцээрээс шууд шалтгаална. Засгийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулах төслийн компани нь “Энержи Ресурс”. Харин Тавантолгойн хөрөнгө оруулалт хийх, тээвэрлэлт болон борлуулалтыг голлон хариуцах нь “Шинхуа Энержи”, “Сумитомо”. “Тавантолгой” төслийг 30 жилийн хугацаагаар нь тооцож үзвэл үржүүлэгч нөлөө нь хамгийн багадаа 94 тэрбум ам.долларт хүрэхээр байгаа юм. Энэ бол хамгийн өөдрөг зураглал. Төслийн нийт хөрөнгө оруулалтын 30 хувийг оролцож буй компаниуд өөрийн хөрөнгөөр, 70 хувийг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээл босгох замаар шийдвэрлэнэ. Монгол Улсын ДНБ 10 тэрбум доллар гэж үзвэл Тавантолгой мега төслийн нөлөө асар их. Үүний цаана мега төслийг дагалдах бизнес дээр хэдэн зуун үндэсний компани ажиллаж, олон мянган хүн ажилтай, амьдралтай болно гэсэн үг. Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани 854 тэрбум төгрөгийн өртэй. Өр “үйлдвэрлэл” тус компанийн менежментийг хувийн хэвшилд шилжүүлэх хэлэлцээр Цагаан сартай золгож байна. ■

Асуудал

# Тавантолгойн төмөр замын “НО”

Б.Тогтох

Уулзах цэгийн түвшингээ өмнө нь хэлэлцэж нарийн тохироогүйгээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам багагүй алдагдалд орж магадгүй нь. Монголын хил хүртэл татсан “Шинхуа Энержи” компанийн төмөр замтай манайхаас ирж буй төмөр зам жигд хэмээр нийлэх ёстой аж. Гэтэл хоёр талаас яваа төмөр зам өндрийн хэмжээгээрээ 30 орчим метр зөржээ. Тиймээс манайх хил рүү тавьж буй төмөр замаа өндөрсгөх шаардлагатай болсон нь Тавантолгойн хэлэлцээрийн явцад ил боллоо. Энэхүү төмөр замын ажлыг “Чингис” бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн бөгөөд мөнгөн дүн нь 280 сая ам.доллар. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд “Шинэ төмөр зам” төсөл хэрэгжиж буй. Уг төслийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам барихаар тогтсон билээ. Зөрүүг ойртуулж, ижил түвшинд хүргэхийн тулд 5.6 км төмөр замын гүүр барих шаардлагатай болж байна.


Энэхүү 5.6 км төмөр замын гүүр нь дэлхийн хэмжээний мега төсөлтэй дүйх бүтээн байгуулалт болж таарах нь. Үүнээс гарч буй эрсдэлийг сааруулж, Монгол Улс өөртөө бус өрөөлд үүрүүлэх сонголт бидэнд бий. Энэ нь “Шинхуа Энержи” өөрийн нутаг дээрх төмөр замын өндрийн уналтаа

намсгах хувилбар. Уг тохиолдолд гүүрний хэмжээ багасч гурван км болох боломжтой аж. Хэмжээ багассан ч гүүр мега төсөл хэвээр үлдэж байгаа. “Шинхуа Энержи” дээрх хувилбарыг Тавантолгойн хэлэлцээрийн үеэр хүлээн зөвшөөрөхгүй бол 5.6 км гүүрэн төмөр замын өөрийн өртөг дунджаар 200-300 сая ам.доллар болж байна. Монгол Улсад хэрэгжиж буй мега төсөлд Оюутолгой, Тавантолгой, Төмөр зам, Тавдугаар цахилгаан станц, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор, Хөшигийн хөндий дэх нисэх онгоцны буудал багтаж буй. Тэгвэл эдгээр мега төсөл дээр нэмээд нэг шинэ мега төсөл үүгээр бий болсныг дээр хөндсөн. Монгол Улсын эдийн засагт хөгжил авчрах мега төслийн нэг нь төмөр зам. Харамсалтай нь, үүнийг хэрэгжүүлэх явцад техник эдийн засгийн үндэслэлд алдаа гарч, улсаараа их хэмжээний хохирол амсах болж байна. Нүүрсээ тээвэрлэх төмөр замтай болох мөрөөдөл өргөн, нарийн цариг тойрсоор он жилийн улс төржилт дагуулсаар сая нэг намжсан. Төрөөс бодлогыг нь эцэслэж, нарийн царигаар тогтоосон ч техникийн алдаа гарчээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг өөрийн хөрөнгө оруулалтаар “Энержи Ресурс”, “Сумитомо”, “Шинхуа Энержи” барина. Төмөр зам ашиглалтад орсноос хойш 30 жилийн дараа 51 хувийг нь төрийн

мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлнэ. Энэ бол сонгон шалгаруулалтын үндсэн нөхцөлд багтсан заалт. Үүнийг хүлээн зөвшөөрсөн Монгол, Хятад, Япон гурван улсын хамтарсан нэгдэл 267 км төмөр замыг барьж дуусгах учиртай. Төмөр зам барих ажлыг “Чингис” бондын хөрөнгөөс 280 сая ам.доллар зарцуулж эхлүүлсэн. Уг хөрөнгийг концерциум Монгол Улсын Засгийн газарт гаргаж өгөх үүргийг хүлээх юм. Гэхдээ мөнгөө сугалж авахын өмнө өнгөрсөн хугацаанд барьж байгуулсан төмөр замын ажлаа манайх хөрөнгө оруулагчдад хүлээлгэж өгнө. Үүний дараа дээр дурьдсан 280 сая ам.доллар Монголын Засгийн газарт шилжих юм. Хараахан хэлэлцээр өндөрлөж, эцсийн дүн гараагүй ч тэд төмөр замд нийт хөрөнгө оруулалтынхаа дөрөвний нэгийг зарцуулахаар байгаа. Урьдчилсан байдлаар 1.1 тэрбум ам.долларыг төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулна. Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх төмөр замын бүтээн байгуулалт нь мега төслийн 50 хувь гэж хэлж болно. Тиймээс Тавантолгойн нүүрс төмөр замгүйгээр том үйлдвэрлэл, том тээвэрлэлт, том борлуулалт хийж чадахгүй гэсэн үг.

Тавантолгой төслийн хамгийн их хөрөнгө шаардах хэсэг нь төмөр зам. Нүүрсний ордын тухай ярьж байгаа ч цаана нь төмөр замын бүтээн байгуулалт гэсэн том ажил хөндөгдөж байгаа. Төмөр замын уулзах цэгийн түвшин зөрсөн нь тэдний /БНХАУ/ бус бидний алдаа болоод үлдэж мэднэ. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам Хятадын төмөр замын сүлжээнд бүрэн нэвтэрч гангийн үйлдвэрүүд төвлөрсөн бүс нутгуудад нүүрсээ нийлүүлнэ. Ингэснээр Монголын нүүрс төмөр замаар далайн боомтод хүрч, гуравдагч зах зээлд гарах боломж бүрдэх юм. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани 2014 онд 5.7 сая тонн нүүрс экспортолсон. Тэгвэл энэ онд өнгөрсөн жилийнхээс хоёр дахин их буюу 11 орчим сая тонн нүүрс олборлохоор төлөвлөөд байгаа. Хэрэв төмөр замаа байгуулбал зардлын өртөг буурч, нүүрсний өрсөлдөх чадвар дээшилнэ. Ингэснээр Монголын коксжих нүүрс БНХАУ-ын зах зээлд “амтлагч” бус захиалга өгөхүйц “хоол” болох юм.



## Аршад Сайед: “Пийбоди” компанийн хувьд урам хугарахаар шийдвэр болсон

Д. Бэхбаяр

*Багагүй цаг хугацааг авсан Тавантолгойн тендерийн ялагчийг тодруулснаас хойш яриа хэлэлцээрүүд үргэлжилж байна. Бас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон өнцгөөс янз бүрийн асуудал хөндөн бичиж байна. Энэхүү тендерт АНУ-ын “Пийбоди” компани нэг оролцогч болж үлдэх нь ойлгомжтой гэсэн дүр зураг олон нийт, бодлого тодорхойлогчдын дунд ч байсан юм. Тус компанийн Монгол, Энэтхэгийг хариуцсан ерөнхийлөгч Аршад Сайедтай ярилцлаа. Түүний ярилцлага олны сонирхлыг татах биз ээ. Аршад Сайед тендерийн сонгон шалгаруулалтаас хойших анхны ярилцлагаа “Mongolian Economy” сэтгүүлд өгсөн юм.*

**-Тавантолгойн тендерийн ялагчид тодорсон. “Пийбоди” компани энэ төсөлд оролцож өрсөлдөхийн тулд долоон жилийн туршид Монголд үйл ажиллагаа явуулсан. Олон нийтийн дунд “Пийбоди” Тавантолгойн төсөлд оролцох нэг компани мөн гэдэг ойлголттой болсон байсан. Гэвч асуудал өөрөөр эргэлээ. Та юу хэлмээр байна вэ?**



-Манай компанийн хувьд харамсалтай шийдвэр болсон. Мөн барууны бусад хөрөнгө оруулагч, ялангуяа уул уурхайн шилдэг техник, технологи, үйлдвэрлэл, байгаль орчинд ээлтэй, аюулгүй ажиллагааны стандарт, зарчмуудыг нэвтрүүлэхийг хичээдэг компаниуд энэ шийдвэрийг тийм ч таатай хүлээж аваагүй болов уу.

**-Үндэсний компанитай хамтарсан байх ёстой гэсэн шинэ заалт оруулсан байхад танайх яагаад ганцаар тендерт орсон юм бэ? Энэ нь л унах гол шалтгаан болсон гээд байгаа шүү дээ?**

-Бидний танилцуулсан тендерийн саналын талаар хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгөх нь төдийлөн зохистой биш юм. Тендерийн нууцлал гэж байдаг. Гэхдээ би зарим нэг зүйлийг хэлье. 2010 онд Тавантолгойн тендер зарласнаас хойш бид гурван Засгийн газрын нүүр үзжээ. Манай компани Тавантолгойн ордыг ямар арга замаар хөгжүүлэх саналаа тухайн Засгийн газар болгоны тавьсан нөхцөл, шаардлагад нийцүүлэн боловсруулж танилцуулж ирсэн.

Анхны үйл явц 2010 онд эхэлсэн.

Тавантолгойн төслийн тендерийн эхний шатанд “Пийбоди” бусад таван компанийн хамт шалгарч, хоёр дахь шатанд гурван оролцогч тодроход ч манайх үлдэж чадсан. Гэвч тухайн үед тендерийн дүнг “ҮАБЗ”-өөс түдгэлзүүлсэн. Хоёр дахь явц 2013 оны сүүлээр Засгийн газраас “Пийбоди”-д хамтран ажиллах санал тавьснаар “Шинхуа”, “Эрдэнэс Тавантолгой”, манай компанийн дунд Тавантолгойн ордыг хөгжүүлэх гурван талт яриа хэлэлцээр 2014 оны нэгдүгээр сард эхэлсэн. Энэхүү гурван талт хэлэлцээр таван сарын туршид амжилттай үргэлжилж, Тавантолгойн төсөлд урт хугацаанд хамтран ажиллах үйл ажиллагааны гол зарчмуудаа тодорхойлсон санамж бичгийн Тавантолгой төслийг эцэслэн боловсруулж, гарын үсэг зурахын өмнө Засгийн газраас гэнэт зогсоосон. Гурав дахь нь 2014 оны наймдугаар сард Засгийн газар Тавантолгойн ордын талаар 268 тоот шинэ тогтоол гаргаж, 2010 онд зогссон тендерийн үйл явцыг өнгөрсөн оны аравдугаар сард дахин эхлүүлсэн. Шинэ тогтоолоор төсөл хэрэгжүүлэх компанид Монголын талын оролцогчийн эзэмшил 51 хувиас



доошгүй байх болон бусад шинэчилсэн нөхцөл, шаардлагуудтай тендерийг нэг сарын хугацаатай зарласан. Дараа нь хугацааг дахин нэг сараар сунгасан. Тэрхүү Шинэчилсэн шаардлагыг хангасан үндэсний компани нь “Энержи Ресурс” байсан. Тус компанитай хамтрах шаардлага гарсан бөгөөд маш богино хугацаанд хамтын ажиллагааны яриа хэлэлцээр хийх хэрэгтэй болсон гэсэн үг.

Тендерт өгсөн саналаа олон нийтэд танилцуулах нь зохимжтой биш гэдгийг дээр хэлсэн. “Пийбоди” компанийн анхнаасаа баримталж ирсэн үндсэн зарчим бол “Тавантолгой” төслийг хөгжүүлэх, ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад Монгол Улсад хамгийн их үр өгөөж, ач холбогдол өгөх үр дүнтэй хувилбарыг сонгох нь нэн чухал гэж үздэг. Үүний тулд хувийн хэвшлийн эсвэл төрийн өмчийн компанитай хамтрах гээд бүх төрлийн хувилбарт бид нээлттэй хандаж байсан. Гэтэл энэхүү тендерийн шаардлагын дагуу үндэсний хувийн хэвшлийн компанитай хамтрах, тэгээд нэг, хоёрхон сарын дотор яриа хэлэлцээр явуулах нөхцөл үүссэн. Бид дээрх үндсэн зарчмаа чухалчлан баримталсан, нөгөө талдаа хугацаа үнэхээр богино байсан тул “Шинхуа” болон “Энержи Ресурс”-тэй хийсэн яриа хэлэлцээр маань тендерийн хугацаанд амжиж тодорхой эцэслэгдэж чадаагүй юм.

**-Мэргэжилтнүүдийн зүгээс “Пийбоди” компани сайн санал өгсөн гэдэг. Харин олон нийтэд, ялагдахаар хэмжээний муу санал өгсөн юм байх даа гэсэн ойлголт байна л даа?**

-Манай компани Тавантолгойн үрт

хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үндсэн зарчмаа өнөөг хүртэл хэвээр хадгалж ирсэн. Бусад оролцогчийн тендерийн санал бидний энэхүү зарчмыг агуулсан бол би сайн гэж үзнэ. “Пийбоди” бол Тавантолгойн ордыг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн шилдэг технологи, шинэ арга барилыг нэвтрүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах, дотоодын жижиг, дунд бизнесийг дэмжих, компанийн засаглалыг бэхжүүлэх, улмаар Монгол Улсыг бүс нутагтаа, олон улсад нүүрсний томоохон тоглогч болгох хэмжээнд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санал боловсруулсан.

Бид Засгийн газрын зүгээс тавьсан тендерийн баримт бичгийн асуулт, заалт бүрт тодорхой хариулт өгсөн. Бид төслийн ойрын хугацааны асуудлуудыг шийдвэрлэхээс гадна иймэрхүү томоохон төслийг хэрэгжүүлэхдээ баримталдаг дунд болон урт хугацаанд 10, 20, 30, 40 жилд тогтвортой ажиллаж чаддаг байхад анхаарч, олон улсын шилдэг менежмент, арга ажиллагааг нэвтрүүлэх, техник, технологи, олон улсын хэмжээний санхүүжилт босгох, нарийвчилсан эдийн засгийн судалгаа, төлөвлөлт хийх асуудлуудыг тусгасан. Тавантолгойг цогцоор нь харж хөгжүүлэхийг зорьсон сайн төслийн санал өгсөн гэж бодож байгаа.

**-Дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унасан энэ үед Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь хэр зөв бэ?**

-Чухал асуулт байна. Төслийн үнэ цэнийг урт хугацаанд нэмэгдүүлэх суурь системийг бий болгох нь өнөөдөр хийх

хамгийн чухал зүйл юм. Үүний тулд уурхайн ашиглалтын үйл ажиллагааг цогцоор нь явуулахад шаардагдах дэд бүтцийг хөгжүүлж, нөөцийг баталгаажуулж, нарийвчилсан судалгаа шинжилгээ, төлөвлөлт хийх шаардлагатай. Хажуугаар нь одоо ажиллаж буй Тавантолгойн уурхайнуудын олборлолтын үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх ёстой. Мөн шаардлагатай санхүүжилтийг босгох ажлыг эхлүүлэх нь зөв. Харин нүүрсний зах зээл сэргэх үед ордоо бүрэн хэмжээгээр

ашиглалтад оруулж, үнэ цэнийг нь өсгөж, үр ашгийг нь хүртэх хэрэгтэй.

**-“Шинхуа”, “Сумитомо”, “Энержи Ресурс”-ын концерциум ийм байдлаар ажиллаж чадах болов уу?**

-Үнэнийг хэлэхэд санаа зовж байна. Бид талуудтай ярилцаж байсан. Харин энэ концерциум бидний хэлсэн саналыг ойлгоод үйл ажиллагаандаа нэвтрүүлээд ажиллавал сайн хэрэг. Тэдний төсөл, төлөвлөгөөг нь сайн мэдэхгүй байна. Гэхдээ энэхүү том төслийг дэлхийн хэмжээнд аваад явах мэдлэг, туршлагатай компаниуд мөн үү гэдэгт эргэлзэж байна. “Шинхуа” бол бүс нутгийн хэмжээнд буюу Хятадад үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн томоохон, чадалтай компани гэдгийг хэлэх хэрэгтэй. Үндэстэн дамнасан олон улсын туршлага гээд яривал арай өөр л дөө. “Энержи Ресурс”-ын хувьд яах аргагүй Монголын нүүрсний том компани. Харин “Пийбоди” нь 130 жилийн түүхтэй АНУ, Австралид үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн дэлхийн хэмжээний компани юм.

**-Одоо “Пийбоди” компани ямар төлөвлөгөөтэй байна вэ?**

-“Пийбоди” Монгол улс дахь үйл ажиллагааны стратегия эргэн харж байна. Цаашид өөр боломжтой төслүүд байх эсэх, эсвэл үйл ажиллагаагаа зогсоогоод бусад оронд анхаарал хандуулахаа удахгүй шийднэ.

Бид долоон жил Монголд ажилласан болохоор өөрсдийгөө Монголын компани шиг л санаж байлаа. “Пийбоди” Монголын хөгжлийн нэг хэсэг. Тиймээс ирээдүйн хөгжилд хувь

нэмрээ оруулахын төлөө явна гэж бодож байсан. Өнгөрсөн нэг сарын хугацаанд болсон үйл явцыг харахад биднийг гаднын компани гэсэн хандлага гаргаж ирсэнд харамсаж байна.

Засгийн газраас тендерийн үр дүнгийн талаар манайд өгсөн албан захидалд “Пийбоди” компани тендерт шалгарч чадсангүй, тендерт оролцсонд баярлалаа” гэсэн маш товчхон мэдэгдэл байв. Урам хугарахаар захидал байлаа. Олон улсын томоохон тэр дундаа барууны хөрөнгө оруулагчид “Пийбоди”-гийн Монголд ажилласан он жил, зарцуулсан хугацаа, идэвх зүтгэл, итгэл найдвар, мөн Засгийн газрын тендерийн сонгон шалгаруулалтын үйл явцыг хараад сэтгэл нь гонсойсон болов уу. Бид өнөөдрийг хүртэл Монгол Улсын төр, иргэдэд хамгийн сайн сайхныг хүсэж ирсэн. Цаашид ч Монголын төр Тавантолгойн ордоо зөв бодлогоор, зөв менежментээр хөгжүүлээсэй гэж хүсэж байна.

**-Та ордын ирээдүйг хэрхэн харж байна вэ. Учир нь та энэ чиглэлээр нэлээд судалсан хүн. Хэрхэн яаж хөгжүүлэх талаар зөвлөгөө өгнө үү?**

-Монгол Улсын нүүрсний салбар онцлогтой. Геологийн тогтоц орд бүр дээр өөр өөр байдаг. Байгаль орчны асуудал маш чухал. Эхлээд Тавантолгойн ордыг хөгжүүлэн ашиглах үндсэн гол зарчмуудыг тодорхойлох ёстой. Тавантолгойн ордын нөөц бол Монгол Улсын үнэт баялаг. Энэхүү баялгийг хэрхэн оновчтой, зөв ашиглах уурхайн ашиглалтын системийг гаргаж ирэх хэрэгтэй. Дэлхийн хэмжээний уул уурхайн цогцолбор болгон хөгжүүлэхэд анхаарч, нүүрс баяжуулах, эцсийн бүтээгдэхүүн болгож, экспортлох, түүнчлэн цаашдаа нүүрс шингэрүүлэх, хий гаргах гэх мэт асуудлуудыг цогцоор нь авч үзэх ёстой. Нэгдсэн дэд бүтцийг байгуулах нь хамгийн чухал. Мөн байгалийн хязгаарлагдмал нөөцүүдийг зөв ашиглах хэрэгтэй. Жишээ нь, усыг зөв зохистой хэрэглэх, уурхайн ашиглалтын байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах хэрэгтэй.

Төслийг цаашид амжилттай хэрэгжүүлэхдээ хэд хэдэн асуудлыг онцгой анхаараасай гэж бодож

байна. Эхлээд төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн судалгаа хийж, бодит нөөцийг тодорхойлж, улмаар урт хугацаанд хэрхэн оновчтой ашиглах төлөвлөгөө боловсруулах ёстой. Нүүрсийг олборлож, боловсруулж, нийлүүлэхэд анхаарах нь мэдээж. “Тавантолгойн нүүрс” гэсэн брэнд бүтээгдэхүүн бий болгож олон улсын зах зээлд нийлүүлэх. Зах зээл уналттай үед бага олборлодог, зах зээл сэргэхэд хэмжээгээ нэмэгдүүлж үйлдвэрлэдэг байх жишээтэй. Хамгийн гол нь зах зээл, худалдан авагчид нийцсэн стандартын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлтэйгээ уялдуулж төлөвлөгөөгөө боловсруулах ёстой. Түүнээс жилд олборлон борлуулах хэмжээг эрс нэмэгдүүлж, энэхүү хэмжээг урт хугацаандаа байнга



ийм байхаар төлөвлөж болохгүй гэсэн санаа.

Дараа нь төслийн санхүүжилтийн төлөвлөгөө. Энэ нь төсөл эдийн засгийн үр өгөөжтэй байхад чиглэнэ. Өөрийн болон зээлийн санхүүжилтийн хоорондын харьцаа ямар байх, санхүүжилтийг хаанаас ямар эх үүсвэрээс олоход бодит тооцоо шаардлагатай. Мөн дотоодын жижиг, дунд компаниудыг дэмжиж, тэднийг хөл дээрээ босоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Ханган нийлүүлэгч, гэрээлэн гүйцэтгэгч байдлаар эдгээр бизнесийг сайтар дэмжих ёстой. Ханган нийлүүлэлтийн гэрээ, үйл явц ил тод, нээлттэй байж, тэгш оролцоог хангана гэдгийг хэлмээр байна.

Хамгийн сүүлд нь ажиллах хүчний асуудал нэн чухал. Төсөл нь хэр олон ажлын байр бий болгох, ажилтнуудыг хаана, яаж, хэрхэн сургах, шинэ техник технологийг хэрхэн нэвтрүүлэн эзэмшүүлэх гэсэн асуудлууд бий.

**-Та Монголд анхлан Дэлхийн банкны Суурин төлөөлөгчөөр ирж байсан. Шийдлийн Засгийн газрын бодлогыг хэрхэн харж байна. Эдийн засгийн уналтыг сэргээх ямар арга зам байна вэ?**

-Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн УИХ дээр хамгийн сүүлд хэлсэн үгийг талархалтай хүлээн авсан. Гол асуудлуудаа тодорхойлсон нь чухал. Олон намын төлөөллөөс бүрдсэн Засгийн газар. Гэхдээ Засгийн газраас хийх ажлууд хүн бүхэнд таалагдах албагүй. Хамгийн зөв гэж үзсэн бодлогоо тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй. Өнөөдрийн эдийн засгийн байдал бол богино хугацааных юм. Түүнийг даван туулж, эдийн засгаа сэргээхийн тулд эрс шийдэмгий бодлогуудыг хэрэгжүүлэх нь зөв.

Би төр, засгийн зарим хүнтэй уулзаж санал бодлоо солилцож байсан. Хамгийн чухал асуудал бизнесийн голлох бараа, бүтээгдэхүүний цикл (мөчлөг) юм. Үүнд анхаарал хандуулж, зөв шийдэл хайх ёстой. Зөв шийдэл нь орлого их олж байх үедээ хадгалах, орлого багасахад хадгалсан мөнгөө зарцуулах. Өнөөдөр Засгийн газар төдийгүй айл өрхүүд ч орлого их олох үедээ тэр хэмжээгээр нь зарцуулдаг. Мөн санхүүгийн болон мөнгөний бодлогыг уялдуулах хэрэгтэй байна. Хэдийгээр эдийн засаг буурсан ч төсвийн хувьд зарцуулах боломжтой орон зайг харах л шаардлагатай. Нөөцийг бүрдүүлж, орлогын тодорхой хувийг Тогтворжуулалтын сан байгуулаад хийж хадгалах нь хамгийн үр өгөөжтэй. Эдийн засаг муудсан үед сангаасаа хэрэглэж, хүндрэлийг давдаг бусад орны жишгийг Монгол Улс мөрдвөл ач холбогдолтой. Эдийн засгийг эргэн сэргээхэд чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх нь үр дүнд хүргэнэ гэж бодож байна. ■

Цаг үе

## М.Энхсайхан: “Пийбоди” хөрөнгө оруулалт хийе гэсэн амлалт өгөөгүй

Б.Эрдэнэ



*Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулагчийг сонгох, хэлэлцээ хийх Ажлын хэсгийн ахлагч Монгол Улсын сайд М.Энхсайханы сэтгүүлчдэд өгсөн ярилцлагын хариултыг хүргэж байна.*

-Тавантолгойн уралдаант шалгаруулалтын нөхцөл нэлээд хатуу. 2010 оноос манай Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруульа гэж байсан, саналаа хэлж байсан компаниудад шинэ нөхцөл тавьж урилгаа явуульа гэж бид тохирсон юм. Энэ дагуу урилга явсан. Урилгыг Хятадын “Шинхуа Энержи”, ОХУ-ын “РЖД” компани, Америкийн “Пийбоди” зэрэг дэлхийн хэмжээний томоохон компанид хүргүүлсэн. Урилгын хариу 2014 оны арванхоёрдугаар сарын 1 гэхэд ирсэн байсан. Үндсэндээ бол хоёр компаниас санал ирсэн гэж хэлж болно. Тэр нь Хятадын “Шинхуа Энержи”,

Японы “Сумитомо”, Монголын “Энержи Ресурс” гэсэн компаниудын консерциум, “Пийбоди” гэсэн Америкийн компаниас ирсэн. Бусад компани нь “Бид нарыг энэ уралдаант шалгаруулалт урьсанд талархал илэрхийлж байна” гэсэн захидал ирүүлсэн байна. Ийм учраас уралдаант шалгаруулалт үндсэндээ хоёр компаний дунд болсон. Бүх ажлын саналыг авч, дүгнэсний үндсэн дээр Монгол, Хятад, Японы хамтарсан консерциум Тавантолгойд хөрөнгө оруульа, үйл ажиллагааг нь явуульа гэсэн санал шалгарсан.

–“Пийбоди” асуудалд хандахдаа арай өөрөөр хандсан юм билээ. Манай Засгийн газрын тавьсан шаардлагыг шууд утгаар нь биелүүлж чадаагүй. Өөрсдийнх нь хандсан хандлагыг бид хүлээн зөвшөөрч байгаа. Тэр нь юу гэхээр “Тавантолгойн нүүрсний орд ямар үнэтэй юм, ямар үнэ цэнэтэй юм, тэр үнэ цэнийг эхлээд гаргая, тэр

үнэ цэнээс нь бодоод бид саналаа хэлмээр байна” гэсэн ийм л санал байсан. Өөрөөр хэлбэл, “Хөрөнгө оруулалт хийе” гэсэн хатуу үүргийг аваагүй. Асуудалд хэрхэн хандах бодол санаагаа хэлсэн. Хүндэтгэж болох үзэл бодол.

–“Пийбоди” компанийн саналын хувьд Засгийн газар маш хатуу нөхцөлтэй уралдаант шалгаруулалт зарласан. Сая дурьдсан дэлхийн том зургаан компанийн дөрөв нь “Баярлалаа” гэж хэлээд хөрөнгө оруулж чадахгүй гэдгээ илэрхийлсэн. Хоёр нь санал ирүүлсэн. Ирсэн санхүүгийн саналын задлаад үзэхээр хөрөнгө оруульа гэсэн амлалт бол аваагүй. Тавантолгойн төсөлд ийм л хөрөнгө оруулах байх. Би төмөр зам барихыг бол чадахгүй. Одоохондоо бид шийдэхгүй. Тийм зүйл ярихгүй. Ийм л саналаа ерөнхийлөн бичиж өгсөн. Манай талаас тавьсан шаардлага бол төмөр замынхаа ажлыг

үргэлжлүүлээд хамтран шийдэх гэсэн тэр нөхцлөөс зайлсхийсэн. Хандлага нь ер нь ямар үнэтэй орд юм бэ. Эхлээд тэрнээс нь хандаж юм хийвэл зүгээр байна гэсэн. Түүнээс тодорхой хөрөнгө оруулалт хийе гэсэн амлалт бидэнд өгөөгүй. Тийм учраас шалгаруулалтад консерциум шалгарсан.

–“Пийбоди” компанийн төлөөлөлтэй уулзаж байхдаа тэдний барьсан философи, үзэл баримтлал Тавантолгойн төсөлд ямар нэгэн хэмжээгээр суух ёстой юм байна гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа. Үүнийг бид консерциумтай дараа ярих байх. “Пийбоди” бас нэг гол шаардлагаа биелүүлээгүй. Монголын үндэсний компанийг өөртөө тээж орж ирэх ёстой байсан. Үндэсний компани дэлхийн зах зээл рүү гаргая. Өндөр чадалтай болгоё. Нэг биш тэрний ард Монголын олон компани өсч, өндийж босч ирэх ёстой. Ийм стратеги зорилго тавьсан. Яг энэ шаардлагад “Пийбоди” тодорхой хариутай орж ирээгүй. Хэрвээ “Пийбоди” шалгарсан консерциумтай хэлэлцээр хийе гэж байгаа бол тэр асуудал тэд нарын асуудал. Энэ бол ажлын хэсгийн ажил биш.

–“Эрдэнэс Тавантолгой” зөвхөн “Чалко”-д өртэй биш. Банкуудад өртэйгөөс гадна бусад өр байгаа. Гэхдээ бид Тавантолгой нүүрсний ордыг ашиглах тухай ярьж байгаа болохоос аж ахуйн байгуулагын өөрийнх нь өр, бусад үйл ажиллагаатай хамаарсан өөр өр зээл байх юм бол тэрнийг хөрөнгө оруулагчидад шууд үүрүүлнэ гэж ярихад хэцүү. Гэхдээ яг энэ ордыг ашиглахтай холбоотой, хөрөнгө оруулагчид зөвшөөрөх ёстой ийм зардал чирэгдэл байгаа бол бид хөрөнгө оруулагчидтайгаа ярьж үүнийг шийдвэрлэх арга замыг олох ёстой. Энэ бол хэлэлцээрийн ширээний ард шийдэгдэх ёстой асуудал.

–Засгийн газрын 268-р тогтоол гарахдаа Баруун, Зүүн цанхи дээр том хөрөнгө оруулагчийг орууля гэж ярьсан. Дээр нь УИХ экспортын бодлогыг нэг цонхоор хэрэгжүүлэх нь үр ашигтай гэдгийг ойлгож байгаа учраас тогтоол гаргасан. Энэ бүгд хоорондоо уялдаатай. Гэхдээ хөрөнгө оруулагчидтай эхлээд хэлэлцээр хийнэ. Хэлэлцээр амжилтад хүрвэл Засгийн газар болоод УИХ-д танилцуулна. Эцсийн шийд тэнд гарна. Тэр эцсийн



шийд гарахтай холбоотойгоор урьд өмнө энэ шийдэлтэй зөрчилдсөн бүх шийдлүүд хүчингүй болох жишээтэй.

–Олон түмэнд тараасан 1072 гэж нэрлээд тогтчихсон хувьцааны асуудал бол үндсэндээ Монгол Улсын Засгийн газрын асуудал. Яагаад гэхээр энэ орд Монгол Улсын төрийн өмч. Монгол Улсын төрийн өмчөөс Монголын ард түмэн хувьцаалаад эзэмших эрхтэй болчихсон байгаа. Энэ зайлшгүй хэрэгжинэ. Чухам яаж, ямар үнийн дүнтэй, хичнээн хэмжээтэй байх уу гэдэг хэлэлцээрээр шийдэгдэнэ. Бүгдээрээ шийдэе гэдэг эрмэлзэл дээр хоорондоо тохирчихсон байгаа.

–Тавантолгойн орд төрийн өмч хэвээр үлдэнэ. “Эрдэнэс Тавантолгой” компанийн боловсон хүчин манай нүүрсний салбарт бэлтгэгдсэн боловсон хүчин. Мэдээж энэ том

төсөлд дайчлагдах нь гарцаагүй. Хэрхэн яаж дайчлагдах гэдэг нь хэлэлцээрийн асуудал. “Эрдэнэс Тавантолгой” нь Монгол Улсын нэрийн өмнөөс лиценз баригчийн хувьд консерциум бидэнд төлбөр төлнө. Төлбөр, яригдаж байгаа хэмжээ нь ашигт малтмалын роялти. Тэр роялтийг 40 хувиар төлөхөд бэлэн байна гэж консерциум мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит лицензийг эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” компани роялти хэрэглэж байгаа нь Монголын хувьд шинэдээд байгаа юм шиг байна. Монголын төрийн өмч учраас, Монголын төрийн өмчийг түрээсэлж байгаа гэдэг утгаар түрээсийн төлбөр гэж нэрлэмээр ч юм шиг ийм юм байна. Анхны тоонуудыг хэлэлцээр эхлэхэд ярьж шийднэ. ■


Хувьцаа

# 1072 хувьцааг амилуулснаар ямар ашиг хүртэх боломжтой вэ

Г. Мөнх-Эрдэнэ

/“Таули” УЦК-ийн хөрөнгө оруулалтын шинжээч/

Нүүрсний нийт нөөц- Нүүрсний ангилалаар



Эх сурвалж: Норвест

## Тавантолгойн нүүрсний орд

Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн тийш 98 км, Цогтцэций сумаас 15 км, Улаанбаатараас 550 км-ын зайд оршдог.

1934 оны үед нутгийн ажигч, гярхай малчид Тавантолгойн нүүрсийг анх илрүүлж түлшиндээ хэрэглэж эхэлсэн.

1966 оны дөрөвдүгээр сарын 18-ны өдөр тухайн үеийн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 124 дүгээр тогтоолоор тус орд газрыг улсын мэдлийнх болгожээ.

## Тавантолгойн нөөцийн тухайд

Оросын Гипрошахт хүрээлэн Тавантолгойн ордын Техник эдийн засгийн үнэлгээг /ТЭЗҮ/ 1989-1990 онд хийхдээ нөөцийн хэсэгчилсэн үнэлгээ, тооцоонуудыг нэгтгэн 6.4 тэрбум тонн

нүүрсний нөөцтэйг тогтоосон.

## Эрдэнэс Тавантолгой гэж юу вэ?

Монгол Улсын Их хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор байгалийн баялгийг үр ашигтай, зүй зохистой ашиглах үүднээс тодорхой ашигт малтмалын ордуудыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан.

“Эрдэнэс Монгол” ХХК (хуучнаар “Эрдэнэс МГЛ” ХХК) нь Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн хорооны тогтоолоор 2007 оны хоёрдугаар сарын 22-ны өдөр байгуулагдсан ба 2010 онд Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулагдсан. Ингэхдээ “Эрдэнэс Тавантолгой”-г “Эрдэнэс Монгол”-ын охин компанийн хэлбэрээр байгуулсан.


Улмаар “Эрдэнэс Тавантолгой”-н 1072 хувьцааг нэг сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоох тухай Засгийн газрын тогтоол гарч, хэрэгжсэн. Үүнтэй холбоотой 2011 оны гуравдугаар сарын 31-нд иргэдэд 536 ширхэг хувьцаа эзэмшүүлэх тухай Засгийн газрын тогтоол гарч байсан бол жилийн дараа буюу 2012 оны дөрөвдүгээр сарын 11-нд нэмж 536 хувьцаа буюу нийт 1072 хувьцаа эзэмшүүлэх тухай тогтоол гарсан билээ. Ингэхдээ 2011 оны дөрөвдүгээр сарын 1-нээс 2012 оны дөрөвдүгээр сарын 1-ний хооронд Монгол Улсын харьяатаас гарсан болон нас барсан иргэнд нэмж 536 ширхэг хувьцаа эзэмшүүлэхгүй бөгөөд зөвхөн 536 ширхэг хувьцаа эзэмшинэ гэж заасан.

## Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар...

2010 онд УИХ-ын 39-р тогтоолоор Тавантолгойн ордыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор хөрөнгө оруулагч шалгаруулах үүргийг тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд Сү.Батболдод өгсөн.

Мөн онд Засгийн газраас уралдаант шалгаруулалт зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо, “Эрдэнэс Монгол” /хуучнаар Эрдэнэс МГЛ/-д үүрэг болгосон. Энэ хүрээнд таван тивийн нийт 15 оролцогч материалаа ирүүлж, эцсийн шатанд зургаан оролцогчийг шалгаруулан, хэлэлцээр хийхээр болсон ч хэлэлцээр удааширч, ҮАБЗ-өөс хэлэлцээрийг хойшлуулсан.

Нөөцийн үнэлгээ ЖОРК стандартаар



Эх сурвалж: “Эрдэнэс Тавантолгой” компанид хийсэн аудитын тайлангаас

### Хэлэлцээр үргэлжилж байна

Харин 2014 оны наймдугаар сарын 24-ний Засгийн газрын 268 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалт явагдаж, Монголын нүүрсний зах зээлийн том үйлдвэрлэгч “Энержи Ресурс” ХХК, Хятадын том тээвэрлэгч “Шинхуа Энержи” ХК, том борлуулагч Японы “Сумитомо” корпорацийн консерциум ялагчаар тодорсон.

Монголын Засгийн газартай хийх хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээр хариуцсан Ажлын хэсэг нь Төмөр зам ба Ордын ашиглалт гэсэн хоёр хэсэгт хуваагдаж ажиллаж байна.

### ТӨСЛИЙН ЭЭРЭГ НӨЛӨӨ

Уг гэрээ зурагдаж, дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт Монголын эдийн засагт орж ирсэнээр ам. долларын ханш сулрахад багагүй нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Үүнээс гадна төслийн хэрэгжилтийг дагаж хангамжийн компаниуд идэвхжих эерэг дам нөлөөг үзүүлнэ. Харин дунд болон урт хугацаанд нүүрсний экспортын тогтвортой орлоготой болсноор валютын дотогшилох урсгал нэмэгдэх эерэг нөлөөтэй бол төсөл амжилттай хэрэгжсэнээр нэг тонн нүүрсний өртөг багагүй хэмжээнд буурч компаниуд ашгаа өсгөх боломж бүрдэнэ. Мөн өндөр үнэтэй зах зээлд нүүрсээ нийлүүлснээр орлого өсөх боломжтой.

### ХУВЬЦААНЫ ҮНЭ ЦЭНЭ

Хэлэлцээрийн явцад нүүрсний нөөц ашиглалтын татвар буюу роялтийн 40 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дансанд шилжүүлж, түүгээр иргэдэд ногдол ашиг тараах боломжийг судалж байгаа юм. Хэрэв уг нөхцөлийн дагуу гэрээг байгуулвал:

Нэг хувьцаанд нэг жилд ногдох ашиг

Хувьсагчид	Тайлбар	Дүн
Борлуулах нүүрсний үнэ - тн ам.доллар	Хятадын нүүрсний далайн зах зээлд нийлүүлэх үнэ	100.00 USD
Борлуулах нүүрсний хэмжээ- тн	ЗГ-ын 268-р тогтоолын дагуу	30 000 000.00
Нийт борлуулалтын орлого - ам.доллар	Нүүрсний борлуулалт	3 000 000 000.00 USD
Роялти-борлуулалтын орлогоос	Хамгийн багадаа 5% Хамгийн ихдээ 10%	150 000 000.00 USD 300 000 000.00 USD
“Эрдэнэс Тавантолгой”-н дансанд	Роялтийн 40 хувийг “Эрдэнэс Тавантолгой”-н дансанд шилжүүлнэ гэвэл	60 000 000.00 USD 120 000 000.00 USD
Иргэдийн эзэмшиж буй хувьцааны тоо - хамгийн ихдээ	Доорх тайлбарыг уншина уу	3 000 000 000.00
Нэгж хувьцаанд ногдох ашиг-ам.доллар	Роялтийг 5 хувиар тооцож авбал Роялтийг 10 хувиар тооцож авбал	0.02 USD 0.04 USD
Доллар төгрөгийн ханш	1 ам.долларыг 1940 төгрөгөөр тооцов	
Нэгж хувьцаанд ногдох ашиг-төгрөг	Роялтийг 5 хувиар тооцож авбал Роялтийг 10 хувиар тооцож авбал	38.80 ₮ 77.60 ₮


Тайлбар:

Анх 3 тэрбум ширхэг хувьцааг иргэдэд хуваарилсан. Гэхдээ тухайн үед иргэдийн тодорхой хэсэг нь хувь хишиг хүртсэн, мөн хувьцаа бус бэлэн мөнгө авах сонголт хийсэн иргэд багагүй байдаг. Хэрэв ЗГ-аас бэлэн мөнгө авах хүсэлт гаргасан иргэдийн мөнгийг олговол хувьцааны тоо 3 тэрбумаас буурснаар нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ өсөх боломжтойг анхаарна уу.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

<b>Богоно хугацаанд</b>	4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт Ажлын байр бий болох, дагалдах бизнесүүд идэвхижих
<b>Дунд ба урт хугацаанд</b>	<b>Экспортын орлого</b> 30 сая тн нүүрс*80 ам.доллар = 2.4 тэрбум ам.доллар <b>Хэмнэх зардал</b> Нүүрсний одоогийн өртөг багагүй хэмжээнд буурах боломжтой. Ингэснээр ашиг нэмэгдэнэ. <b>Хувьцааны үнэ цэнэ</b> ЭТ-д нүүрсний борлуулалтын татварын 40 хувийг нь шилжүүлж, түүгээр иргэдэд ногдол ашиг тараах боломжийг хэлэлцэж байна.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол



Эх сурвалж: Оросын Гипрошахт хүрээлэн Тавантолгойн ордын Техник эдийн засгийн үнэлгээг



**Анхааруулга:** Энэхүү тооцоо нь “Хөрөнгө оруулалтын гэрээг дээрх нөхцөлийн дагуу байгуулагдсан тохиолдолд” гэсэн таамаглалд үндэслэж байгаа учир бодит байдалтай зөрөх талтай. Тиймээс бодит байдалд нэг хувьцаанд ногдох ашиг дээрх тооцооллоос өөр байх боломжтойг анхаарна уу. ■



Хөрөнгө оруулалт

## Шинэ хандлага

Б.Өнөболд

“Дэлхийн хэмжээнд Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын орчин удаан ч гэсэн сайжирч байна” гэж НҮБ-ын Худалдаа хөгжлийн хороо /XXX/ үзэж байна.


Чухамдаа 2013 онд ГШХО 1450 тэрбум ам.доллар буюу есөн хувиар нэмэгдсэн бөгөөд 2014 онд 1600 тэрбум ам.доллараар нэмэгдэх хандлагатай байна.

2013 оны байдлаар орж, гарч буй ГШХО-аар хөгжиж буй зах зээл тэргүүлжээ. Хөгжингүй орнууд руу урсах ГШХО-ын хэмжээ есөн хувиар буюу 566 тэрбум ам.доллараар нэмэгдэж нийт урсгалын 39 хувийг эзэлсэн

байхад хөгжиж буй орнуудынх 778 тэрбум ам.доллараар нэмэгдэн ГШХО-ын 54 хувийг эзэлсэн нь өмнө нь байгаагүй өндөр үзүүлэлт. Үлдсэн 108 тэрбум ам.долларын ГШХО хөгжлийн шилжилтийн шатанд байгаа орнуудад хийгджээ. ГШХО татах чадвараараа дэлхийн топ 20 орны тал хувийг хөгжиж буй болон хөгжлийн шат руу шилжиж буй орнууд эзэлж байна.

Хөгжиж буй зах зээл дэх ГШХО мөн урьд өмнө тэмдэглэгдэж байгаагүй үзүүлэлтэд хүрчээ. Хөгжиж буй орны үндэстэн дамнасан корпорациуд (ҮДК) өөрийн бүс дэх хөрөнгөтэй орнуудын охин компаниудыг худалдан авах

хандлага нэмэгджээ. Гадагш чиглэх нийт ГШХО-ын 39 хувь буюу 553 тэрбум ам.доллар хөгжиж буй болон хөгжлийн шилжилтэд байгаа орнуудаас эх үүсвэртэй байна. Энэ нь 2000 оны эхээр 12 хувьтай тэнцэж байсан хөрөнгө оруулалтын үзүүлэлтээс гурав дахин их гэсэн үг. Үүнээс гадна ядуу, буурай орнууд уул уурхайн салбараас хэт хамааралтай байх хандлага буурах төлөвтэй байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд уул уурхайн салбарт хэрэгжиж буй, хэрэгжихээр байгаа байгаль орчны нөхөн сэргээлтийн төслийн нийт хувь Африк тивд 26, бусад буурай хөгжилтэй оронд (БХО)



36 хувьтай байсан. Энэ үзүүлэлтүүд хурдацтай буурч байна. Учир нь Африк тивд болон буурай хөгжилтэй орнуудад шинэ төслүүдийн 90 хувь нь үйлдвэрлэл болон үйлчилгээний төсөл байгаа аж.

### Хөрөнгө оруулалтын бодлогын хандлага болон гол хөндөгдөж буй асуудлууд

Олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй хөрөнгө оруулалтын гол бодлогуудын үндсэн чиглэл нь сурталчилгаа болон чөлөөт бодлогод чиглэх хандлагатай байна. Нөгөө талаас хяналтын эсвэл хязгаарласан хууль тогтоолын хэмжээ 2013 оны байдлаар 27 хувиар нэмэгджээ. ГШХО-аас эдийн засаг нь шууд хамаардаг орнууд орж ирээд байгаа хөрөнгөө алдахгүйг хичээж байгаагийн илрэл энэ юм. Учир нь

зарим хөрөнгөтэй оронд ҮДК-аа эргүүлэн нутагтаа суурьшуулах бодлого явуулж эхлээд байна.

НҮБ-ын ХХХ-ны тооцоолсноор 2013 онд 59 орон 87 төрлийн гадаадын хөрөнгө оруулалтад нөлөөлөх бодлого хэрэгжүүлжээ. Эдгээрээс 61 нь хөрөнгө оруулалтыг чөлөөлөх мөн хялбарчлах бодлогууд байсан бол 23 нь хөрөнгө оруулалтыг шинээр хянаж, хязгаарлах хууль тогтоол байна. Хөрөнгө оруулалтыг шинээр хянаж хязгаарлах хууль тогтоолын хэмжээ 2012 оныхоос 25 хувиас ялимгүй өсөж 2013 онд 27 хувьд хүрчээ. Хөрөнгө оруулалтын нийт бодлогын тал хувийг бүх нийтээр хэрэгжүүлж байна. Түүнчлэн үйлдвэрлэлийн салбарт хамаарах бодлогуудын ихэнх хувийг үйлчилгээний салбарт төвлөрүүлжээ.

Хөрөнгө оруулагч татах урамшуулал нь тогтвортой хөгжлийг дэмжихээс илүү эдийн засгийн үзүүлэлтэд түлхүү анхаарал тавьж байна. Улс орнуудын Засгийн газар хөрөнгө оруулагчдыг татах үүднээс урамшуулалыг бодлогын хэрэгсэл болгон ашигладаг. Гэхдээ үүнийг эдийн засгийн түвшинд үр дүнгүй, улсын төсвийг буруу зарцуулж байна гэж үзэх нь бий. Олон улсын хөрөнгө оруулалтын хууль тогтоол нэг талаас хөрөнгө оруулалтын зуучиллын хувьсаас үүдэн нийтлэг тогтолцооноос салах, нөгөө талаас гэрээ хэлэлцээрийг нэмэгдүүлэх, сайжруулах гэсэн салаа чиг хандлагатай байна. Өдгөө олонтаа яригдаж буй мега төслүүд энэ чиг хандлагын илрэл юм.

### Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин

Хөрөнгө оруулалтын шинэ хуулийн хүрээнд Монголын Засгийн газар НҮБ-ын Худалдаа, хөгжлийн хороогоор (ХХХ) Хөрөнгө оруулалтын хуулийн хяналт хийлгүүлсэн. Үүний зэрэгцээ Олон улсын худалдааны байгууллагаар Гадаад худалдааны бодлогоо мөн хянуулсан билээ. Ингэснээр Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтаас үүдсэн хөгжлийн бололцоогоо бүрэн ашиглаж ГШХО-ын орж ирж буй урсгалыг төрөлжүүлэх бодлого явуулж байна.

НҮБ-ын ХХХ-оос гаргасан тайлангаас харахад Монголд орж ирж байгаа хөрөнгийн урсгалыг уул уурхайн салбараас гадна бусад салбарт чиглүүлэх боломж байгааг тодорхойлсон байна. Хөгжүүлэх бололцоотой салбаруудад аялал жуулчлал, бизнесийн болон санхүүгийн үйлчилгээ, дотоодын үйлдвэрлэл мөн хөдөө аж ахуйн салбаруудыг дурьджээ.

Ийнхүү 2014 оноос эхлэн Монголын Засгийн газар хөрөнгө оруулалтаа төрөлжүүлэх бодлогыг НҮБ-ын ХХХ-оос санал болгосны дагуу баримталж буй. Тус бодлогын хэрэгжилтийн явцад гарсан өөрчлөлтүүдийг дурьдвал

- Хөрөнгө оруулалтын хуульд

өөрчлөлт оруулахад хамгийн түрүүнд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын ялгааг багасгасан. Үүгээр гадаадын хөрөнгө оруулагчдын эрхийг урьд өмнөхөөс чанартайгаар хамгаалдаг болсон гэж ойлгож болно.

- Түүнчлэн хөрөнгө оруулалтын чанарыг сайжруулах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчдад 100 мянган ам.долларын хөрөнгийн доод хэмжээний босгыг бий болгожээ.
- Мөн шинэ хууль өмнөхөөсөө тогтвортой болсон гэж болно. Учир нь Их хурлын гишүүдийн гуравны хоёрын саналаар хуульд өөрчлөлт оруулах боломжтой ажээ.
- Энэ бүх өөрчлөлтийг дэмжиж, хэрэгжүүлэх үүднээс Хөрөнгө оруулалтын шинэ агентлаг үүд хаалгаа нээж, Монголын шинэчлэл өөрчлөлтийг дэлхий дахинд танилцуулах ажлыг үүрэг болгон хүлээн авсан байна. Энэ сурталчилгааны ажлаас гадна тус агентлаг нь гадаад хөрөнгө оруулагчдад зөвлөгөө өгөх мөн тэдний эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын

бодлогын “төв” нь төрөлжүүлэлт. Хөрөнгө оруулалтын агентлагийн мэдээлж байгаагаар 2014 оны хувьд нийт 800 сая ам.доллар гадаадын 300 гаруй уул уурхайн бус компаниар дамжин Монголд орж иржээ.

Монголын хөрөнгө оруулалтын агентлагийн Сурталчилгаа зөвлөгөөний хэлтсийн дарга Д.Ирмүүн “Хөрөнгө оруулалтын хувьд хэцүү байсан ч 2014 он хөрөнгө оруулалтын орчны хувьд онцгой жил болсон. Өнгөрсөн жилийн хугацаанд бид хөрөнгө оруулалтын эрүүл мөн аюулгүй орчныг бүрдүүлж чадсан” гэсэн юм.

Ингээд Монголын Засгийн газар ирэх жилд орж ирэх ГШХО-ын урсгалд ихээхэн найдвар тавьж байна. Төрөлжүүлсэн бодлого үр шимээ өгөөд эхэлсэн. 2014 онд уул уурхайн бус салбарт 800 сая ам.долларын хөрөнгө оруулалт татаж чаджээ.

Засгийн газрын хувьд төрөлжсөн бодлогоо цаашид хэрэгжүүлж уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх бодлогоо үргэлжлүүлэх юм байна. Ингэснээр “Оюутолгой”, “Тавантолгой” зэрэг том хэмжээний уул уурхайн төсөлтэй холбоотой эрсдэлийг бүүруулна. ■

## Судалгаа

## Тэнгэр бүрхэх цагаар


## А.Бүрэнжаргал

Аливаа бизнесийн үйл ажиллагаа эрсдэлд орох, эдийн засгийн нөхцөл байдал муудах үед хэрхэн бэлтгэлтэй байх аргыг олон улсад шуудуугаа төлөвлөх гэж ярьдаг. Энэ нь тэнгэр бүрхэх цагаар хэрхэн ажиллахаа төлөвлөх, эрсдэлээ урьдчилан тооцоолох арга ухааныг хэлж буй. Яг л ийм үе Монголд тохиооод байна. Манай улсын бизнесийн орчны нөхцөл байдал хийсэн “Монголын бизнесийн орчны үндэсний хэмжээний судалгаа”-нд манай улс базаахгүй үнэлгээ авлаа. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаатай судалгаанд оролцогчид санал нэгдсэн. Тэгвэл гарц нь юу вэ гэвэл ажлын байр. Үүнийг шийдэхэд үр нөлөө үзүүлэх чухал тоглогч нь хувийн хэвшил. Иймд “Тэдэнд боломж олго, хүлээсээс нь чөлөөл” хэмээн дээрх судалгааны үр дүнгийн талаар Монгол дахь Америкийн худалдааны танхимын ТУЗ-ийн дарга Жаксон Кокс хэллээ.

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж аж ахуйн нэгж, байгууллагууд цомхотгол хийж байгаа нь ажилгүйдлийг өсгөх ноцтой асуудал төдийгүй иргэдийн амьжиргааны түвшинтэй шууд холбоотой. Энэ талаар эдийн засагч Б.Дөлгөөн “Эдийн засаг дотроо ажилгүйдэлд яагаад ийм өндөр ач холбогдол өгч байгаа учир нь статистикийн газрын мэдээллээр өнгөрсөн онд 105 мянган иргэн шинээр ажилгүй гэж бүртгүүлсэн байдаг. Гэхдээ 60 мянга орчим нь эргээд ажилтай болсон байдаг” гэлээ. Харин энэ он гарсаар ажилгүй иргэд нэмэгдэж байгаа нь тэдний худалдан авалт буурах, цаашилбал эдийн засгийн сэргэлтийг улам хойш татахаар байна.

Судалгаанд оролцогчдын 39 хувь нь ажилгүйдэл улс орны хэмжээнд тулгарч

Монгол улсад тулгарч буй эдийн засгийн асуудлууд




буй гол асуудал гэсэн. (Хүснэгт 1).

Мөн өндөр татвар, зээл авах боломж, макроэдийн засгийн тогтворгүй байдал, төрийн байгууллагын авлига, улс төрийн байдал тогтворгүй байгаа нь тулгамдаж буй асуудлын жагсаалтыг тэргүүлжээ.

АНУ-ын Олон улсын хөгжлийн

хүнд жил байлаа. Манай компани 20 гаруй жил Монголд үйл ажиллагаа явуулж байна. Бид үйл ажиллагааны зардлаа танасны дээр хүний нөөцөө ч цомхотгоод байна. Манай ажилчдын 98 хувь нь монголчууд байдаг” гэсэн юм. Мөн тэрбээр “Энэ жил Монголын Засгийн газрын зүгээс үр дүн өгөхүйц арга хэмжээ хэрэгжүүлээсэй гэж хүсч байна” гэсэн юм. Макроэдийн засгийн тогтворгүй байдал, төсвийн алдагдал болон гадаад өр өндөр байгаа зэрэг нь ойрын ирээдүйд бизнес хөгжиж, дэвшихэд тушаа болно гэж судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь үзжээ. Тиймээс бодлогын оновчтой шийдвэр гаргах нь зүйтэй гэдгийг мэргэжилтнүүд

Монголын бизнесийн орчинд тулгарч байгаа хамгийн том бэрхшээл



агентлагаас манай улсад 2012 онд явуулсан “Авилгын талаарх олон нийтийн ойлголт” судалгаагаар оролцогчдын 56 хувь нь татвар өндөр байгаа нь хамгийн том бэрхшээл гэж үзсэн бол энэ удаа 15.5 хувь болж буурсан сонирхолтой үзүүлэлт гарчээ.

“Вагнер Ази” компанийн захирал Стив Поттер “2014 он бол бизнес эрхлэгчдийн хувьд бэрхшээл, саад ихтэй

сануулж байгаа юм.


Оролцогчдын 73 хувь нь хувийн хэвшлийнхнийг ажил олгодог, улсын төсвийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулдаг, үр ашигтай, шуурхай ажиллагаатай гэж дүгнэжээ. Түүнчлэн бизнес эрхлэлтийн орчны судалгаанд улс төрийн шинжтэй асуултыг багтааснаараа онцлог. Тодруулбал, улс орны эдийн засгийн байдал хийгээд хувийн хэвшлийнхний

үйл ажиллагаанд улс төрчдийн гаргасан шийдвэр хамгийн их нөлөөтэй. Ямар ч хувийн хэвшлийн байгууллага төрийн гаргасан хууль, дүрмийн дор ажилладаг учраас ийм төрлийн асуултууд багтаах нь чухал гэж судалгааны баг үзжээ.


Хувийн хэвшлийн цаашдын хөгжлийг хангахад тулгарч буй гол бэрхшээлүүдийн талаар 56.3 хувь нь инфляци, төсвийн алдагдал, гадаад өрийн хэмжээгээр илэрхийлэгдэх эдийн засгийн тогтворгүй байдал гэж үзсэн байна. Харин 15.5 хувь нь хөрш орнуудаас эдийн засгийн хувьд хараат байгаа явдал гэсэн бол 9.5 хувь нь уул уурхайн салбараас хэт хараат байгаа нь хувийн хэвшлийн хөгжилд тушаа болж байна гэжээ.

Түүнчлэн 2013 оны таван сард хийсэн судалгаанд хамрагдагсдын 58 хувь нь бизнесийн орчин сайжирна гэсэн эерэг хандлагатай байсан бол саяхны судалгаанд тус хандлага тогтмол буурсаар байгааг онцолжээ. Тиймээс олон нийтийн итгэлийг сэргээж бодлогын оновчтой, урт хугацаандаа тогтвортой байх шийдэлд хүрэх хэрэгцээ бийг судалгааны үр дүн харуулж байна. Гаргасан шийдлийнхээ эцсийг үзэж эдийн засгаа аврах ажилд оюун ухаан, сэтгэл зүрхээ “чилээх” цаг иржээ. ■

Төрийн аль байгууллага бизнесийн хөгжилд хамгийн ихээр саад учруулж байна вэ?



Хувийн хэвшлийн ирээдүйн хөгжилд тулгарч буй асуудал



Бизнес зөвлөгөө



## Удирдлагуудын гаргадаг таван том алдаа

Ажлын ярилцлагын арга барилд байгууллага бүрт харилцан адилгүй. Түгээмэл явцаас харахад бүх шатны ярилцлага нийт дөрвөн цаг, бичиг цаасны ажил нийт хоёр цаг шаарддаг байна. Ийнхүү шинэ хүчээр “цус сэлбэх” амаргүй ажилд тухайн байгууллага зургаан цагийн хөдөлмөр зарцуулдаг аж.

Цаг, мөнгө шаардах энэхүү хүнд даалгаварт удирдлагууд өвдөг шороодох эрсдэл бий. Иймд түгээмэл алдаа гаргалгүй төлөвлөгөөгөө сайтар боловсруулахаас гадна байгууллагад

ашигтай, тууштай шийд гаргахын тулд дараах зөвлөгөөг санахад илүүдэхгүй ажээ.



### Тодорхойгүй байдал тун халгаатай

Удирдлагууд юу хүсч, хэнийг хайж буйгаа сайтар мэдэх хэрэгтэй. Ингэснээр тухайн ажлын байранд шаардагдах боловсон хүчнийг сонгоход хялбар болохоос гадна цаг хэмнэх юм. Мөн ажлын сонгон шалгаруултад ирж буй хүмүүст тухайн ажлын талаарх мэдээллийг маш тодорхой ойлгуулах нь зүйтэй. Ажил олгогчийн зүгээс туршлага болон чадвар гэдэг үгсийн утгыг зөв ялгах явдал чухал байдаг аж. Тухайбал, мэргэжлээрээ нэлээд олон жил ажилласан хүн илүү туршлагатай байна гэж туйлширч болохгүй. Тэр тусмаа ажлын байраа олон сэлгэсэн хүнийг “мундаг” гэж үзэх нь удирдлагуудын гаргадаг нийтлэг том алдаа ажээ. Иймд тоонд хууртан шийд гаргах бус тухайн ажлын байрны чиг, үүргээс хамааран гүйцэтгэлийн чадамжийг үнэлэн тохиромжит нэр дэвшигчийг сонгоход анхаарлаа хандуулах хэрэгтэй юм байна.

### Боломжгүй хүлээлт мөрөөдөл төдий

Бага өртөгөөр ихийг бүтээх хүсэлдээ автах явдал байгууллагуудын удирдлагуудад ажиглагдах нь бий. Хэдийгээр энэ нь бизнесийн нэг зарчим боловч хүний нөөцийн хувьд мөрөөдөл төдий үлддэг. Харамсалтай нь, дийлэнх тохиолдолд байгууллагууд “төгс” нэгнийг хайсаар тухайн ажилд тохирохуйц боловсон хүчнээ алдаж орхидог. Тиймээс төгс мөрөөдөл хөөж цаг гарздах хэрэггүй. Хөдөлмөрийн зах зээл гэх том далайгаас ямар загас шүүрдэх боломжтой вэ гэдгээ сайтар бод. Бодит төсөөлөлтэй бай. Мөн ярилцлагын цагаа зах зээлийн судалгаа хийх таатай боломж гэж хүлээж авах хэрэгтэй.



### Сулбагар ярилцлага хэнд ч ашиггүй

Зөв совиндоо хэт найдах хэрэггүй. Ажлын ярилцлагад ашиглах асуултуудаа цаасанд буулган оролцогч бүрээс тэдгээрээ асуу. Ингэснээр хариултад үндэслэн оролцогчдыг харьцуулан ажиглах боломжтой болно. Гэхдээ “Өөрийгөө танилцуулахгүй юу” гэх мэт улиг болсон “жизүүрийн” асуултаас зайлсхийгээрэй. Учир нь үнэт цагаа сулбагар асуултаар үрэхийн оронд мэдээлэл авч болохуйц асуулт сонголт хийхэд тустай.



### Та яст мэлхий биш

Удирдлагууд өөрийн бизнестэй холбоотой асуудалд няхуур хандах нь аргагүй. Гэхдээ тоймтой шийдвэрт хүрэхгүй хэт удах нь тэдний нийтлэг алдаа гэнэ. Хэдийгээр хамгийн сайн сонголт хийхэд багагүй цаг зарцуулах шаардлагатай ч хүлээлгэх зуур тань боломжийн сайн гэсэн боловсон хүчин хэдийнэ ажлын байртай болчихсон байхвий. Учир нь чадварлаг хүний нөөцөд ажлын байр үргэлж нээлттэй. Иймд аль болох шаламгай байхыг хичээх хэрэгтэй юм байна.

### Халах гэж бүү үд

Шинэ ажилчин гэж удаан бүү өршөө. Тухайн ажилд тохиромжгүй гэж үзсэн тохиолдолд халах арга хэмжээг даруй авах хэрэгтэй. Байдал сайжирна гэсэн хүлээлт бизнесийн үйл ажиллагаанд халтай гэдгийг үргэлж санах нь чухал. Удирдлага та “Ажилд авах гэж яарах хэрэггүй ч халах гэж удах бас хэрэггүй” гэсэн зарчмыг үргэлж баримтлах ёстой аж. ■





ANNIVERSARY

# COAL MONGOLIA 2015

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 5 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER  
2015 ОНЫ 4 САРЫН 9-10



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР:



ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



**БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА**



COAL MONGOLIA ХУРЛЫН ҮЕЭР

○ ХУРАЛ

○ ҮЗЭСГЭЛЭН

○ УУРХАЙТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ



Дэлгэрэнгүй мэдээллийг:

[WWW.COALMONGOLIA.MN](http://WWW.COALMONGOLIA.MN)



976-70115590



info@coalmongolia.mn

Ярилцлага

## Жаксон Кокс: 2015 он шийдлийн жил байгаасай

Б.Наранцогт



Монгол дахь АНУ-ын Худалдаа аж үйлдвэрийн танхим (АмЧам)-ын ТУЗ-ийн дарга Жаксон Кокстой Америк, Монголын бизнесийн салбарын хамтын ажиллагааны боломжуудын талаар ярилцлаа.

**-АмЧам Монголд анх хэрхэн байгуулагдаж байсан талаар яриагаа эхлэх үү?**

-АмЧам Монголд 2011 онд анх байгуулагдсан. Байгууллага албан ёсоор бүртгүүлснийхээ дараа Америкийн “Пийбоди”, “Женерал Электрик”, “Вагнер Ази”, Монгол талаас “Магнай Трэйд” зэрэг компанитай холбогдон санал тавьж байлаа. Анх боловсон хүчнээ бүрдүүлж байсан тэр цагаас хойш чамгүй сайн өргөжлөө. Одоогоор 40 гаруй байгууллага манайд гишүүнчлэлтэй. Хамгийн гол нь АмЧам гишүүдийнхээ сайн түнш болж, Монгол, АНУ-ын хооронд худалдааг дэмжих зорилготой ажиллаж байна.

**-Та 2015 он Монгол Улсын бизнесийн орчинд хэр ээлтэй жил байна гэж харж байна вэ?**

-2015 оны бизнесийн орчинг дүгнэхийн тулд бид 2013, 2014 оныг эргэн харах хэрэгтэй. Эдгээр он Монголын эдийн засагт хүнд жилүүд байсан. Бидний харж байгаагаар сүүлийн хоёр жилд гарсан эдийн засгийн удаашрал, капиталын дайжилтын дараа үлдсэн бизнес эрхлэгчдийн бүлгээс одоогийн эдийн засаг хамаарч байна. Одоогийн бизнесийн орчны сорилтыг ойлгохын тулд энэ хямрал бодлого тодорхойлогчдын гаргасан шийдвэрээс үүссэн гэдгийг ойлгох нь чухал гэж бодож байна. Би өнгөрснийг сөхөх дургүй. Бас өөрийгөө их өөдрөг хүн гэж боддог. Энэ 2015 он шийдлийн жил

байгаасай. Учир нь тийм шийдлүүдийн үр дүнд тогтвортой хөрөнгө оруулалтын орчин үүсэх бөгөөд энэ нь эдийн засагт итгэл төрүүлэх юм. Тэгэхээр зөв шийдвэр, зөв шийдэл гарч байж зөв үр дүн гарах юм.

**-УИХ-аар батлагдсан АНУ, Монгол Улсын хоорондын Ил, тод байдлын хэлэлцээрт АмЧам нэлээн идэвхтэй оролцсон. Энэ хэлэлцээр ямар ач холбогдолтой вэ? Монголын эдийн засагт ямар нөлөө үзүүлэх бол?**

-Үнэнийг хэлэхэд АмЧам энэ ажилд их сүүлдэж оролцсон л доо. Хамаг чухал ажлыг нь АНУ, Монгол Улсын Засгийн газрууд олон жилийн хэлэлцээрийн дүнд харилцан тохиролцсон. Ийм чухал бас том амжилт гаргасанд нь тэдэнд баяр хүргэх хэрэгтэй. Энэ бол маш чухал хэлэлцээр. Жишээ нь, Ил тод байдлын хэлэлцээрт “Худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой ямар ч хуулийг батлахаас өмнө олон нийтэд Англи, Монгол хэлээр танилцуулж, 60 хоногийн турш иргэд, хувийн хэвшлийнхний дунд санал асуулга явуулна” гэж заасан. Азид өрнөж буй улс хоорондын худалдааны гэрээ, хэлэлцээрүүдийг харахад олон зүйлийг ажиглаж болно. Саяхан Австрали улс Япон, Өмнөд Солонгостой чөлөөт худалдааны гэрээ байгуулчихлаа. Солонгос, Япон, Хятад улс хамтран хэлэлцээр хийж байна. Хятад АСЕАН-ы орнуудтай хэлэлцээр хийж байна. АНУ Ази, Номхон далайн 12 оронтой хэлэлцээр хийж, түүхэн дэх хамгийн том чөлөөт худалдааны “Транс-Пасифик түншлэл” гэрээг үзэглэх гэж байна. Эдгээр хэлэлцээрийн нийтлэг тал нь юу вэ гэхээр улсууд хоорондоо бүтээгдэхүүн, үйлчилгээ чөлөөтэй солилцох боломж олгохоос

гадна бодлогын маш өндөр стандарт тогтоодог. Жишээ нь, оюуны өмч, байгаль орчныг хамгаалах, хөдөлмөр, ил тод байдал зэргийг хамарсан маш өндөр стандарттай байна гэсэн үг. Тэгэхээр АНУ, Монгол Улсын хоорондын Ил, тод байдлын хэлэлцээр бий болсноор Монгол Улс Ази, Номхон далайн бүсийн бусад орны адил өндөр стандартыг баримталж, олон улсын зах зээлийн тоглоомд оролцоход бэлэн болсон гэдгийг илэрхийлж байгаа юм.

**-АмЧам Монгол Улсыг АНУ-ын компаниудад хэрхэн сурталчилан таниулдаг вэ?**

-АмЧам жил бүрийн зургаадугаар сард АНУ руу худалдааны аялал зохион байгуулдаг. Аялалд оролцогчдын дийлэнх нь Америк компанитай хамтрах хүсэлтэй Монгол компани байдаг. Мөн бид бүсийн уулзалт хийдэг. Америк компанийн төлөөллүүдтэй уулзахын тулд хаа холын АНУ руу явах шаардлагагүй. Тэдгээр компани Азид салбаруудаа нээн ажиллаж байна. Монгол Улс АПКАК буюу Америкийн худалдааны танхимуудын Ази, Номхон далайн зөвлөлийн гишүүн орон. АПКАК нь Ази, Номхон далайн бүсийн АмЧамуудын бүлэг гэсэн үг. Энэ зөвлөл тогтмол хуралддаг бөгөөд бид ирэх гуравдугаар сард Сингапурт болох энэ жилийн бизнесийн уулзалтад оролцож Монголын компаниудыг танилцуулна.

**-Америкийн эсвэл гадны компанитай хамтрах хүсэлтэй Монголын бизнес эрхлэгчид, компаниудад та юу гэж зөвлөх вэ?**

-Бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ зах зээлийн боломжийг судалж, гэрийн даалгавараа сайн хийгээрэй гэж зөвлөмөөр байна. Дараа нь бэлтгэлээ сайн хийх хэрэгтэй. Судалгаа, бэлтгэлээ сайн хийх гэдэг бол миний өгөх гол зөвлөгөө. Монголын зах зээл, эдийн засагт амжилттай хэрэгжих ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ байна вэ. Дараа нь Америкийн ямар түнш хамгийн тохиромжтой вэ. Америкийн аль компани үүнд тохирох технологи, дэд бүтэц, инженерингийн аргачлалтай вэ гээд судлах зүйл их байна. Ази тив, бүс дотроо хийгдэх гэж байгаа эсвэл амжилттай хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр зэргийг ажиглаж хараасай гэж хүсч байна. ■



Өр гэж юу вэ? Засгийн газрын гадаад өрөнд ямар асуудлыг хамааруулан ойлгох вэ? Тэрхүү өр хэдий хэмжээнд хүрээд байгаа вэ?

Өдөр хоногоор өссөөр байгаа Монгол Улсын өрөнд нөлөөлж байгаа хүчин зүйлс юу болох, бидэнд өрийн дарамтад орохгүй байх боломж бий юү? Эдгээр асуултад манай сонирхуулж буй тусгай судалгаа хариулт өгөх болно.

ӨР

# Засгийн газрын гадаад өрийн тойм

“Бодлогын судалгаа” буландаа Нээлттэй нийгэм форумын захиалгаар судлаач Л.Гангэрэлийн хийсэн Засгийн газрын гадаад өрийн тойм /2000-2015/ судалгааг түүвэрлэн хүргэж байна. Өрийн удирдлагын тухай хуулийн төслийг УИХ-аар удахгүй хэлэлцэх гэж байгаа энэ үед хууль тогтоогчид болон шийдвэр гаргах түвшний уншигчдад маань нэлээд хэрэгтэй мэдээлэл байх болов уу.

Уг судалгаа Засгийн газрын гадаад өрийн талаарх ойлголтууд, Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн байдал, 2015-2017 оны Засгийн газрын гадаад өрийн төлөв, эрсдэл, Гадаад өрийн дарамтад орж байсан хоёр орны жишээ, Эрх зүйн зохицуулалтын өнөөгийн орчин, Дүгнэлт, Бодлогын зөвлөмж гэсэн зургаан хэсгийг агуулгатаа багтаажээ.

## Засгийн газрын гадаад өрийн талаарх ойлголтууд

**Дэлхийн банкны тодорхойлолт:** Засгийн газрын болон Засгийн газрын нэгжүүд, мөн Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчдийн урт хугацаанд гадаад улсад төлөхөөр, Засгийн газрын баталгаа гаргасан хувийн хэвшлийн байгууллагын гадаад улсад төлөхөөр үүрэг хүлээсэн өрийн нийлбэрийг Засгийн газрын гадаад өр гэнэ.

**ОУВС-гийн тодорхойлолт:** Гадаад өр гэж тухай оронд оршин суугч нь гадаад улс руу шилжүүлэх үүрэг хүлээсэн төлбөрүүдийн нийлбэрийг хэлнэ.

**Төсвийн тогтвортой байдлын тухай хууль:** “улсын өр” гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газрын гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг хэлнэ.

## Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн байдал

Монгол Улсын Засгийн газрын боловсруулсан 2015 оны улсын төсвийн төсөлд дурьдсанаар 2012-2014 онуудад

- (i) дотоод өрийн зах зээлийг хөгжүүлэх,

Засгийн газрын гадаад өрийн талаарх ойлголтууд



Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн байдал



санхүүжилтийн эх үүсвэрийн 40 хувийг дотоод өрийн зах зээлээс бүрдүүлэх,  
(ii) Нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээг үе шаттайгаар бууруулах хоёр зорилт тавьж ажилласан байна.

## Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төлөв байдал, эрсдэл

Харин 2015-2017 онуудад Засгийн газрын гадаад өр, зээлийн талаар

- (i) Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг бэхжүүлэх,
- (ii) Засгийн газрын өрийн багцын зохимжит бүтцийг бий болгох, валютын ханшийн эрсдэлийг бууруулах,
- (iii) Засгийн газрын гадаад зээллэгийн эх үүсвэрийг хамгийн бага зардлаар авах үндсэн гурван зорилт тавьж байна.

## Засгийн газрын гадаад өрд нөлөөлөгч хүчин зүйлс

Валютын ханш, Дотоодын нийт бүтээгдэхүүн, Зээлжих зэрэглэл, Улсын бодлого, институцийн үнэлгээ,

Арилжааны зээлийн жишиг хүүний түвшин

## Валютын ханш

Сул валюттай Засгийн газрын гадаад өр нь ихэнх тохиолдолд гадаад валютаар үүсгэгдэж, гадаад валютаар төлөгдөхөөр байдаг. Манай улсын үндэсний валют нь олон улсын зах зээлд зарагддаггүй учир бүх гадаад өр нь гадаад валютаар үүсгэгдсэн байна.

Сүүлийн гурван жилд төгрөг нь ам.долларын эсрэг дараалан 7,12,18 хувиар тус тус сулраад байна. Эндээс харахад төгрөг нь ам.доллар болон бусад гадаад валютын эсрэг эрчимтэй суларч байна.

## Зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл тогтоодог гурван агентлаг сүүлийн нэг жилийн хугацаанд манай улсын Засгийн газрын зээлжих зэрэглэлийг бууруулсан бөгөөд хоёр агентлаг нь цаашдын хандлагыг сөрөг гэж үнэлсэн нь цаашид ч зэрэглэл

Засгийн газрын гадаад өрийн төсөөлөл

Үзүүлэлтүүд	2014-09-30 Гүйцэтгэл	2015	2016	2017
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
<b>Засгийн газрын гадаад өрийн дүн</b>	<b>8,977.80</b>	<b>9,230.00</b>	<b>9,288.30</b>	<b>7,971.80</b>
<b>Тэрбум төгрөгөөр</b>				

Эх сурвалж: Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ,

буурах эрсдэлтэй байгааг илэрхийлж байна.

**Арилжааны жишиг хүү**

Энэ нь харьцангуй хэлбэлзэл өндөртэй байгаа нь гадаад өрийн өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг тодорхой хугацааны дараа эрсдэлд оруулж болох магадлал өндөр байна.

**Гадаад өрийн дарамтад орж байсан хоёр орны жишээ**

Аль ч улсын Парламент Засгийн газартаа гадаад өр төлбөрийн сайн хяналт тавьж байх шаардлагатай Засгийн газрын гадаад өрийн асуудал нь зөвхөн улсын гадаад өрөөс гадна хувийн хэвшлийн гадаад өрийн менежменттэй салшгүй холбоотой асуудал

-ЗГ-ын гадаад өр ба хувийн хэвшлийн гадаад өрийн асуудлыг хамтад нь

хөндсөн, гадаад өрийн дарамтад орж байсан хоёр орны жишээг авч үзье. Үүнд: - Чили, Аргентин орно.

**Гадаад өрийн дарамтад орж байсан Чили:**

-Чилийн их өрийн уг эх сурвалж нь 1975 оноос эхлэлтэй хувийн хэвшлийн хяналтгүй, их хэмжээний зээллэгтэй холбоотой

-1979-1982 онд үйлчилж байсан тогтмол ханшны бодлогоос улбаалан гадаад валютын зээл нь харьцангуй хямдаар олдож байсан

-Нэмээд Төвбанкнаас дотоодын банкуудын гадаадаас авах зээлд тавих хязгаарлалтыг 1980 онд үгүй хийсэн

-Дээрх бүх арга хэмжээнүүдийн дүнд Чилийн Засгийн газрын гадаад өр эдийн засгийн их идэвхжлийн үедээ (1982-1988) 6.6 тэрбум ам.доллараас

13.2 тэрбум хүртэл, хувийн хэвшлийн гадаад өр 807.0 сая ам.доллараас 10.6 тэрбум ам.доллар болж өссөн

**Гадаад өрийг бууруулах талаар Төвбанк, Засгийн газраас хамтран авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:**

-Гадаад өрийн төлөх хугацааг сунгах,

-Үндсэн төлбөр болон хүү төлөх хугацааг өөрчлөх - зарим зээлүүдийн хувьд зээлийг эргэн үнэлэх

- Зээлийн төлбөрийг хийхийн тулд шинээр мөнгөний нийлүүлэлт хийх амлалт авах зэрэг ажлуудыг гадаадын зээлдэгчтэй хамтран хийсэн

**Мөн Төв банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:**

-Олон улсын бондын зах зээл дээр 30 хүртэл хувиар хямдраад байсан Засгийн газрын бондоо эргүүлэн худалдан авах

- Хувийн хэвшлийн гадаад өрийг хөрөнгөжүүлэх (өрийг хувьцаанд хөрвүүлэх механизм)

Ингэж ажилласны үр дүнд: Засгийн газар гадаад өрийн 14 хувийг эргүүлэн худалдан авах механизмаар, хувийн хэвшлийн гадаад өрөө хөрөнгөжүүлэх схемээрээ 624 сая ам.доллараар багасгаж чадсан

**Гадаад өрийн дарамтад орж байсан 2 орны жишээ: Аргентин**

Латин Америкийн орнуудын зээлийн их хямралын үед Аргентин 1982 онд өөрийн анхны гадаад өрийн дефолтоо зарласан

ОУВС, Дэлхийн банкны өгсөн заавар зөвлөмжийг сайтар биелүүлж, онц үнэлгээ авсны үндсэн дээр 1994 оноос эхлэн Аргентин улс гадаад өрийн зах зээлд нэвтрэх боломжтой болсон бөгөөд 1992-1999 онд гадаад өр нь 61 тэрбум ам. доллараас 145 тэрбум болтол огцом өссөн

**Гадаад өр огцом өссөн шалтгаанууд:**

1989-1990 оны өндөр инфляцийн дараа эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх нэрийдлээр гадаад худалдаа, хөрөнгийн гадагшлах урсгалыг либералчилсан


Түүнчлэн гадаад валютын хөрвөх хууль гэгчийг гаргаж ам.долларыг песотой 1:1 гэсэн тогтмол ханшаар уяж өгсөн

Гадаад худалдааны чөлөөлөлт болон тогтмол ханшны бодлого нь гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлж, гадаадаас зээллэг авахаас аргагүй

Засгийн газрын гадаад зах зээлд арилжаалсан бонд

<b>Хэмжээ:</b>	<b>500 сая ам.доллар</b>	<b>1 тэрбум ам.доллар</b>
<b>Хугацаа:</b>	5 жил	10 жил
<b>Дуусах өдөр:</b>	2018 оны 1 дүгээр сарын 5	2022 оны 12 дугаар сарын 5
<b>Хүү:</b>	4.125%	5.125%

Эх сурвалж: Сангийн яамнаас гаргадаг тайлан болон Хөгжлийн банкны вэб хуудас



Эх сурвалж: Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ  
Тэмдэглэл: хувиар

байдалд хүргэсэн

### **Гадаад өрийн дарамтад орж байсан дээрх хоёр орны жишээнээс авах сургамжууд:**

-Хувийн хэвшлийнхээ гадаадаас авах зээллэгийг зохицуулж, хязгаарладаг арга механизмыг сайтар боловсруулж, түүнийгээр мөрдөж байх

-Төвбанк нь Засгийн газартайгаа хамтран өөрийн орны онцлог тохирсон гадаад өрөө багасгах стратеги төлөвлөгөөг боловсруулан түүнийг улс төрийн нөлөөнөөс харьцангуй ангид хэрэгжүүлж чадвал гадаад өрийн дарамтнаас гарч болдог

- Гадаад валют, гадаад худалдааны үйл ажиллагаагаа хэт либералчлах бодлого явуулах нь эдийн засгийн хөгжил, бизнесийн өрсөлдөх чадвар дорой улсуудын хувьд хүндээр тусч болдог

-Эдийн засгийн томоохон реформыг ихээхэн тооцоо судалгаатай, тухайн улсынхаа гадаад болон дотоод өрийн байдал, нийт макро эдийн засгийн хэтийн төлөвтэйгээ уялдуулан авч хэрэгжүүлэх шаардлагатай

-ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын тухайн орны эдийн засгийн талаар өгч буй заавар зөвлөгөөг өөрийн орны онцлог, гадаад болон дотоод улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулан авч үзэн тэдгээр зөвлөгөөг авч хэрэгжүүлэх эсэхээ шийдэж байх нь чухал

### **Эрх зүйн зохицуулалтын өнөөгийн орчин**

Манай улсад өрийн удирдлагын талаар тусгайлсан хууль байхгүй бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуулинд нэр томъёо болон зарим нэг шаардлага, зохицуулалтыг тусгасан байна.

Мөн Засгийн газар нь өрийн удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулаад байгаа ба одоогоор хэлэлцүүлгийн шатанд явж байна.

### **Төсвийн тогтвортой байдлын тухай хууль**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд улсын өрийн тодорхойлолт, улсын өрийн хязгаар болон уг хязгаарыг хэрхэн мөрдөх тухай зохицуулалтыг оруулсан байна.

Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8

дугаар заалтад “улсын өр” гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газрын гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээр өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг ойлгоно гэжээ. Уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад “уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан байна.

### **Төсвийн тухай хууль**

-Төсвийн тухай хуулинд өр, өрийн хэрэгсэл болон болзошгүй өр төлбөр зэргийг тодорхойлсон ба мөн Засгийн газрын өрийн удирдлагын талаар зохицуулалтуудыг тусгасан байна.

-Уг хуулинд “өр” гэж өрийн хэрэгслээр дамжуулан тухайн этгээдээс бусад этгээдийн өмнө ирээдүйд эргэн төлөх төлбөрийн үүргийг хэлнэ гэж өргөн утгаар нь тодорхойлсон ба “өрийн хэрэгсэл” гэж бүх төрлийн зээл, үнэт цаас болон өр үүсгэх аливаа гэрээ, хэлцлийг хэлнэ гэжээ.

-Төсвийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд зааснаар Засгийн газар нь дараах зорилгоор өр үүсгэж болно.

-Засгийн газрын төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;

-Улсын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх;

-Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх;

-Хүүгийн хэмжээ болон зардлыг бууруулах зорилгоор өрийг дахин санхүүжүүлэх;

-Улсын төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх;

-Уг хуульд зааснаар “болзошгүй өр төлбөр” гэж Засгийн газрын гаргасан

баталгааг хангах, эсхүл үндэсний аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөөс хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээтэй холбогдон төсөвт үүсч болзошгүй эрсдэлийг мөнгөн дүнгээр тооцож илэрхийлснийг хэлнэ гэжээ. Тухайн жилийн төсөвт тусган, баталсан хүрээнд Засгийн газраас гаргах өрийн баталгааг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн батална.

-Засгийн газрын зээл болон улсын өрийн удирдлага, түүний стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх нь Засгийн газрын бүрэн эрх юм. Уг хуулинд “Засгийн газрын өрийн удирдлага” гэж Засгийн газрын дунд болон богино хугацааны санхүүгийн зардал, эрсдэлийн түвшинг тодорхойлох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ гэжээ.

-Төсвийн тухай хуулинд хөрөнгө, өр төлбөрийн удирдлага, Засгийн газрын зээл авах, зээл олгох, дамжуулан зээлдүүлэх, өрийн баталгаа гаргах, тэдгээрт тавигдах шаардлага, нөхцөл, хязгаарлалт, болзошгүй өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна гэсэн байна.

### **Өрийн удирдлагын тухай хуулийн төсөл**

-Өнөөдрийг хүртэл улс орны хэмжээнд өрийн удирдлагын талаар нэгдсэн цогц бодлого байхгүй байна

-Үүнийг засаж залруулахын тулд Өрийн удирдлагын тухай хуулийн төслийг Засгийн газраас боловсруулж УИХ-д өргөн бариад байна.

-Гол агуулга нь өрийн удирдлагыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар менежмент хийж, өрийн тогтвортой байдлын стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газрын нийт өрийг бүртгэх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

### **Хуулийн гол заалтууд:**

Шинээр дараах нэр томъёог албан ёсоор тусгаж өгсөн байна. Үүнд: “улсын нийт гадаад өр” гэж Засгийн газар, орон нутаг болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүргийг

“өрийн үйлчилгээ” гэж зээлийн

Засгийн газрын зээлийн гол онцлог нь харьцангуй хүү бага, хугацаа урт байдаг бөгөөд нэмэлт олон төрлийн нөхцлүүдийг заасан байдаг.

Зээлийн ангилал	Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	Эргэн төлөгдөх хугацаа	Хүүний хэлбэр	Хүүний түвшин
Хөнгөлөлттэй олон талт зээл	10	40 жил	Тогтмол	0.75%
Хөнгөлөлттэй хоёр талт зээл	7	20 жил	Тогтмол	2.00%
Арилжааны олон талт зээл	5	20 жил	LIBOR+1.25	2.89%
Арилжааны банкны зээл	4	9 жил	CIRR+1.5	3.14%

Эх сурвалж: Ё.Амарбат, Засгийн газрын өрийн удирдлага, Илтгэл, Сангийн яам

### Засгийн газрын баталгаа

№	Баталгаа гаргуулагч	Огноо	Шийдвэрлэсэн хэмжээ	Ашигласан хэмжээ /2014-09-30/
1	Хөгжлийн банк /гадаад үнэт цаас/	2012	580 сая ам.доллар	580 сая ам.доллар
2	МИАТ ТӨХК /ЭКСИМ банкны зээл/	2013	121.4 сая ам.доллар	121.4 сая ам.доллар
3	Хөгжлийн банк /Самурай бонд/	2014	30 тэрбум иен	30 тэрбум иен
4	Хөгжлийн банк /Credit Suisse-ийн зээл/	2014	300 сая ам.доллар	180 сая ам.доллар
5	Хөгжлийн банк /БНХАУ-ын зээл/	2014	162 сая ам.доллар	112 сая ам.доллар

Эх сурвалж: Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

### Засгийн газрын гадаад өрийн тогтвортой байдал



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

үндсэн болон хүүгийн төлбөр, шимтгэл, холбогдох бусад төлбөрийг

-Өрийн удирдлага нь нэгдсэн удирдлагын тогтолцоотой байх бөгөөд 6.2.3 Засгийн газрын зээллэг, өрийн баталгаа нь УИХ-аар, орон нутгийн зээллэг нь Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагддаг байх;

-УИХ өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: 7.1.1 төсөв, мөнгөний бодлогын хүрээнд Засгийн өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг хуульчлан батлах; 7.1.3 Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

#### -5. Стратегийн бичиг баримт

15.2 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага нь стратегийн баримт бичгийг 3 жилд нэг удаа боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт батлуулахаар Засгийн газарт өргөн мэдүүлнэ.

-Өрийн хязгаар, түүний үйлчлэл

17.1 Засгийн газрын өрийн үлдэгдлийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдсэн дүн нь тухайн төсвийн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдхүүний 60 хувиас хэтрэхгүй байна.

-Засгийн газрын зээллэг болон өрийн баталгааны дээд хэмжээг тогтоох

18.1 Жил бүрийн төсвийн хуулиар Засгийн газрын тухайн төсвийн жилд хийх зээллэг болон өрийн баталгааны дээд хэмжээг тогтооно.

18.3 Засгийн газраас гаргасан

өрийн баталгааны үлдэгдлийн нэрлэсэн үнийн дүн нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдхүүний 20 хувиас хэтрэхгүй байна

#### Бодлогын зөвлөмж

- ОУВС-гийн Засгийн газрын гадаад өрийг тооцоолдог аргачлалын дагуу Монголбанкны гадаад өрийг ЗГ-ын гадаад өрөнд оруулж тооцоолох
- Засгийн газраас Хөгжлийн банк, Засгийн газрын бондуудын үндсэн төлбөр болон хүүг хэрхэн төлөх нарийвчилсан стратеги төлөвлөгөөг боловсруулж, УИХ-аар нэн яаралтай батлуулах
- Монгол Улс өөрийн гадаад бонд болон бусад гадаад өр төлбөр дээрээ дефолт болвол ямар хариуцлага хүлээх, үүний эсрэг ямар арга хэмжээ авах талаар судалгааг ЗГ-аас яаралтай хийх
- Өрийн удирдлагын тухай хуулийг нэн яаралтай УИХ-аар батлуулж, түүнд оруулах өөрчлөлтийн саналын квотыг өндөрт тавьж өгөх
- Цаашид ЗГ эсвэл Хөгжлийн банк гадаад бонд гаргах болон гадаад их хэмжээний зээллэг авахдаа түүнийг юунд зарцуулах төсөв төлөвлөгөөгөө УИХ-аар урьдчилан батлуулж байх
- Хувийн хэвшлийн гадаад өрийг улсын нэгдсэн гадаад өрийн бүртгэлд бүрэн хамруулан бүртгэдэг олон улсын стандартыг нэн даруй нэвтрүүлж хэрэгжүүлэх
- Төвбанк, Сангийн яамтай хамтран хувийн хэвшлийн гадаад өрийн зохицуулалтыг хийх хууль эрх зүйн механизмыг бий болгож, хэрэгжүүлэх
- Нэн тэргүүнд ашиглах боломжтой ашигт малтмалын стратегийн ордуудын гадаад хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахдаа нэг шалгуур үзүүлэлтээр нь урт хугацаат, хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэр өгөх гэж сонгон, уг эх үүсвэрээр богино, хугацаатай, өндөр өртөгтэй гадаад өрөө төлөх
- ОХУ-аас импортолдог нефть, шатахууныг махны бартер худалдаа болон Оросын Төвбангтай рублийн своп хэлцэл хийх замаар рублиэр худалдан авах арга замыг эрэлхийлж, гадаад валютын гадагшлах урсгалыг багасгах ■

**Ард Кредит ББСБ таны санхүүгийн хэрэгцээнд шаардлагатай бүх төрлийн зээлийн үйлчилгээг санал болгож байна.**

*Түргэн шуурхай, Уян хатан, Найрсаг үйлчилгээ*

## **ШУУРХАЙ** ЗЭЭЛ

Таны богино хугацааны санхүүгийн хэрэгцээнд зориулсан барьцаат зээл

- Хэмжээ: 50 сая төгрөг хүртэл
- Хугацаа: 10 сар хүртэл
- Барьцаа: үл хөдлөх хөрөнгө, хашаа байшин, автомашин (тавих болон унаж явахаар)

## **БИЗНЕСИЙН** ЗЭЭЛ

Таны бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ

- Хэмжээ: 150 сая төгрөг
- Хугацаа: 18 сар хүртэл
- Бүх төрлийн барьцаа тавьж болно

## **ЦАЛИНГИЙН** ЗЭЭЛ

Хамтран ажиллах гэрээтэй байгууллагад ажилладаг ажиллагсдын өрхийн хэрэгцээнд зориулсан зээл

- Хэмжээ: 20 сая төгрөг хүртэл
- Хугацаа: 12 сар хүртэл
- Ажил олгогчтой хийсэн хамтран ажиллах гэрээний үндсэн дээр олгоно

**Хэвлэлийн мэдээ:**

Ард Кредит ББСБ ХХК-ийн 2015 оны анхны ТУЗ-ийн хурал амжилтай болж өндөрлөлөө. Энэ удаагийн ээлжит хурлаар 2014 оны ажлаа дүгнэж, 2015 оны төсвөө баталсан бөгөөд Компани үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш анх удаа ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасныг мэдэгдэхэд баяртай байна. Энэхүү шийдвэрийн талаар Компанийн ТУЗ-ийн гишүүн Н.Эрдэмбаяр “Ард Кредит санхүүгийн хямралтай жилийг амжилттай даван туулж хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг өсгөхийн зэрэгцээ анхны удаа ногдол ашиг тараах шийдвэр гаргасан нь компани эрүүл, зөв замаар хөгжиж байгааг илтгэж байна” гэж онцоллоо.

2014 онд хэдийгээр эдийн засаг, бизнесийн орчин сайнгүй байсан хэдий ч Компани 85 хувийн өсөлттэй ажилласан бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөжийг 21 хувьд хүргэлээ. 2014 онд Ард Кредит нь Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан болон дотоодын банкнаас санхүүжилт аван, анхны Хаалттай өрийн бичиг гаргаж, Итгэлцэлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл аван дотоодын зах зээлээс санхүүжилт босгосон амжилттай ажиллав.

Ард Кредит нь 2011 онд үүсгэн байгуулагдан Монгол Улсад бичил зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэлийн гишүүн компани юм. Бидний эрхэм зорилго орчин үеийн дэвшилтэт аргачлалыг ашиглан бичил зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэхэд оршино.

Ард Санхүүгийн Нэгдэл буюу Ард Холдингс нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт х, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. Манай бүрэлдэхүүнд Ард Даатгал, Ард Кредит, Монет Капитал, Ард Актив, Ард Капитал Менежмент болон Хөрөнгө Оруулалтын Итгэлцлийн Сан (EIT) багтаж байна. Ардын хөрөнгө оруулалтын сангаас Техник Технологийн Дээд Сургууль, Номын Хишиг, Уайлд Дижитал Эйжэнси, ТэнГэр Системс зэрэг компанид хөрөнгө оруулалт хийн удирдлагад нь идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын ажиллагааны үндэс суурийг бий болгож ажиллаж байна.



## Давосын өртөг

Б.Үүрийнтүяа

АНУ-д 4.79 ам.доллараар авч болох Макдоналдс түргэн хоолны газрын нэг “Бигмак” бургер сет Швейцарь улсад ойролцоогоор найман ам.доллар болж огцом өсөв. Учир юу вэ гэхээр Швейцарийн Төвбанк мөнгөн тэмдэгтээ еврогийн эсрэг өсгөхгүй гэх бодлогоо цуцалсан нь тус улсын франк бусад валюттай харьцах үзүүлэлтийг цойлоход хүргэж, улмаар бараа, бүтээгдэхүүн мөн үйлчилгээ гээд бүхий л салбарын өртөгийг ийн тэлэхэд хүргэсэн. Швейцарийн барьсан гэнэтийн “бэлэг” дэлхийн эдийн засаг, бизнесийн салбарт цохилт өгч, Давосын чуулганыг зорих “эгэл” гийчдэд ч хүнд тусав бололтой.

Он гармагц дэлхий нийт Давост уламжлал болгон зохион байгуулагддаг Дэлхийн эдийн засгийн чуулганаар “амьсгалдаг” заншилтай. Өргөн хүрээнд хэлэлцэгдэх үндсэн сэдвүүдээс гадна Швейцарь франкийн ханш өссөн нь энэ жилийн чуулганд оролцогчдын дунд дуулиант сэдэв болов.

Хэдийгээр дэлхийн баячууд Давосын нүүр царай болов ч чуулганыг зорьсон олонх хэсэг ханшийн чангаралд тодорхой хэмжээгээр өртсөн нь дамжиггүй. Тухайлбал, Хятадын Сиамин их сугуулийн Эрчим хүч, эдийн засаг судлалын төвийн захирал Лин Бокиан “Чуулганд оролцсоныхоо дараа хэд хоног цанаар гулгах сайхан байдаг. Гэхдээ энэ жил Давост нэг өдөр илүү өнгөрөөхгүй гэж шийдсэндээ баяртай байна” хэмээн Давост өнгөрүүлсэн дөрвөн өдрийн томиллолтоо дүгнэв. Түүний хэлж буйгаар зочид буудал, өглөө, оройн хоол гээд урсгал зардал хэтэрхий үнэтэй тусаж байгаа аж.

Арга ч үгүй. Өнгөрсөн жил дундаж зоогийн газар хооллоход дунджаар 40 ам.доллар байсан бол энэ удаа 50 ам.доллар төлөөд гарах нь энүүхэнд байсан аж. Тэгвэл дундаж зэрэглэлийн зочид буудал чууганы өдрүүдэд 600-700 ам.доллар “нэхэж” байх жишээтэй. Өнгөрсөн жил 80 ам.доллараар морин тэргээр хотыг тойрох боломжтой байсан бол өнөөгийн ханшаар 92 ам.доллар зарцуулах болжээ. Давосыг зорих “чухал” эрхмүүд “Belvedere” тансаг зэрэглэлийн зочид буудалд тухлах дуртай гэнэ. Тэгвэл тус зочид буудалд нэг жилийн өмнө 41 ам.доллар төлөөд Johnny Walker Blue (виски) нэг хундага хүртэх боломжтой байсан бол өдгөө зургаан ам.доллар нэмж төлөх аж. “Seehof” зочид буудалд нэг шил 2004 оны “Dom Perignon” дарс 400 ам.доллар болжээ. Тус улсын Төвбанкны шийдвэрийн өмнө дээрх дарс 343 ам.доллар байж.

Швейцарь улс дэлхийн өртөг өндөртэй орнуудын тоонд орсоор ирсэн. Давос хот өртөг өндөртэй топ хотуудын эгнээнд багтдаг. Тэгэхээр Дэлхийн эдийн засгийн чуулганыг зорих ханш өндөр гэдгийг хүн бүр мэднэ. Гэвч өнгөрсөн жилийн өртөгтэй харьцуулахад хэдийнэ 15 хувиар нэмэгдээд байсан үзүүлэлт франк өссөнөөр улам цойлсоныг дээрх энгийн жишээнүүд харуулж буй. Тэгвэл энэ жилийн чуулганд оролцохын тулд хичнээн ам.доллар зарцуулах шаардлагатай болсныг дурьдахад илүүдэхгүй. Энэ удаагийн чуулганд дэлхийн 40 орчим улсын төрийн тэргүүд цугласан төдийгүй 2500 орчим зочид, төлөөлөгчид оролцсон гэсэн тоо бий.

Тэднийг дагалдан дэлхийн өнцөг булан бүрээс нийт 250 сэтгүүлч ажиллажээ. Төрийн тэргүүд, Засгийн газруудын төлөөлөгчид гээд “VIP”-чууд цагаан мандатаар “дархлагдсан”. Гэвч тэд чуулганд оролцогчдын ердөө нэг хувийг бүрдүүлдэг. Тэгэхээр тэднээс бусад нь зохих төлбөрөө төлөөд чуулганы нэг хэсэг болно гэсэн үг. Тодруулбал, энэ оны Дэлхийн эдийн засгийн чуулганд оролцох хүсэлтэй байгууллагууд (тус улсын Төвбанкны шийдвэрээс өмнө) өнгөрсөн жилийнхээс 20 хувиар нэмэгдсэн үнээр гишүүнчлэлийн эрхээ авахаар болсон. Харин франкийн ханшийн өсөлтөөс үүдэн чуулганд оролцох зэрэглэлээс хамааран 90 мянган ам.доллар хүртэлх төлбөрийг нэмж төлөх шаардлагатай болов. Түүнчлэн байгууллагууд мандатын тоо бүрээр 20 мянган ам.доллар нэмж төлсөн аж. Мөн чуулганыг зохион байгуулагчдын зүгээс топ категори гэгдэх корпорациудын гишүүнчлэлийн нэг жилийн эрхийг 600 мянган франк буюу 673 мянган ам.доллар болгохоор төлөвлөж байгаа аж.

Франк ийн чангарсан нь оролцогчдыг “төрөлжүүлж” байгаа гэх. Учир нь хэн дуртай нь мөнгөө төлөөр ирдэг газар Давос биш гэдгийг олонд түгээх хөшүүрэг болно гэж зарим төлөөлөгч үзжээ. Тэгэхээр эдийн засгууд хямраад, дампуураад байгаа энэ үед хэрэгтэй, хэрэггүй олон “сүүл” дагуулан үргүй зардал гаргахгүй байх асуудалд орнуудын Засгийн газар, бизнесийн байгууллагууд анхааран ажилласан байх гэж бодном. ■

# Хямралтай жил-ОХУ

Б.Өнөболд

Оросын холбооны улс (ОХУ)-ын хувьд 2014 он хүнд жил болж өнгөрлөө. Украйны мөргөлдөөн, эдийн засгийн уналт, рублийн сулрал гээд олон асуудал тулгараад байна. Зарим эдийн засагчийн үзэж байгаагаар 1998 оноос хойш тохиогоогүй хүнд байдал ОХУ-д нүүрлээд байгаа юм.

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын дундуур рублийн ханш түүхэнд үзэгдээгүй доод түвшиндээ хүрсэн бөгөөд тухайн өдөр нэг евро 100 рубльтэй, нэг ам.доллар 80 рубльтэй тус тус дүйж байсан.

Өнгөрсөн онд ОХУ-ын мөнгөн тэмдэгт ам. долларын эсрэг нийт 60 хувиар буурсан байна.

Уналтын шалтаан нь ОХУ-ын эдийн засгийг газрын тосны ханш болон барууны орнуудын хориг арга хэмжээнүүд “хэврэгжүүлж” буйд оршино.

Украйны асуудлаас улбаалаад Европын холбоо, АНУ тус улсад эдийн засгийн хориг тавьсан. “Газета” болон Оросын бусад дотоодын мэдээллийн хэрэгслээр Украйны дайн тус улстай “Ажил хэргийн холбоо үүсгэх бололцоотой байсан хөрөнгө оруулагчдийг үргээж байна” гэж үзэж байна. Түүнчлэн ОХУ-д эргэлдэж байсан гадны хөрөнгө их хэмжээгээр тасарч байгааг онцлох нь зүйтэй. Оросын Төвбанкны мэдэгдэж

байгаагаар 2014 онд 128 гаруй тэрбум ам.доллар гадагшилсан бөгөөд энэ нь 2013 онтой харьцуулахад хоёр дахин их байгаа юм.

Удаах асуудал нь газрын тосны ханшийн уналт. ОХУ-ын эдийн засаг газрын тосны ханшаас шууд хамааралтай (График 1-2).

Өнгөрөгч оны арваннэгдүгээр сард ОХУ-ын Сангийн сайд Антон Силуанов газрын тосны ханш унаснаар тус улс 100 сая орчим ам.долларын алдагдал хүлээж болзошгүйг сануулж байсан.

Иймд ОХУ-ын Засгийн газар 2015 онд 0.8 хувийн эдийн засгийн уналттай байна гэх таамаг гаргаад байгаа бөгөөд энэ нь өнгөрсөн оны 0.6 хувийн үзүүлэлтээс бууна гэсэн үг. Оросын Төвбанкны үзэж байгаагаар тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 4.5-4.8 хувиар буурах төлөвтэй байгаа юм.


Өнгөрсөн оны наймдугаар сард ОХУ өрсөлдөгч орнуудын зүгээс орж ирж буй импортын барааг хааж эхэлсэн. Үнийн хөөсрөлт асар хурдтай нэмэгдэж байгаа гол шалтаан нь хориг арга хэмжээ болон рублийн сулралд оршиж байна. Оросын Төвбанк нийт хөөсрөлтийн хэмжээг 11.5 хувьтай болох “аюулын дохио” өгөөд байгаа.

Оросын “Газета” сэтгүүлийн мэдээлснээр оросууд ийм хүндрэлийг даван туулсан туршлагатай. Иймээс хэрэглэгчид үнийн хэт хөөсрөлтөөс амжин цахилгаан болон тавилгын дэлгүүрээс их хэмжээний худалдаа хийсэн байна. 1998 оны эдийн засгийн уналтын үетэй адил дэлгүүрүүд үнээ нэмэн рубль, ам.долларын хосолсон шошго нааж эхэлжээ.

График 1. Рублийн ханш ам.доллортой харьцуулахад



График 2. Түүхий газрын тосны ханш




(Эх сурвалж : Boursorama.com)

Оросын Төвбанк бодлогын хүүгээ 6.5 нэгжээр өсгөж 17 хувь хүргэсэн нь ганхаж буй эдийн засгийн байдлыг улам хүндрүүлж байна. Өнгөрсөн оны эхээр 5.5 хувь байсан бодлогын хүү тус оны дунд үеэс 10.5 хувь хүртэл өссөн. Төвбанкны энэ бодлого нь одоогийн Монголбанкны бодлоготой дүйцэхээр гэж болно. Энэ нь улсынхаа мөнгөн тэмдэгтээр хадгалагдаж буй хөрөнгийн орлогыг өндөр байлгах. Хөрөнгийн орлогыг үнийн хөөсрөлөөс дээгүүр авч явах, улмаар дотоод мөнгөн тэмдэгтээ бусад валют руу хөрвөх урсгалыг хаах. Хөрөнгө өөр орон руу алдагдахаас сэргийлэх гэсэн зорилго агуулж буй.

Оросын Төвбанкны ерөнхийлөгч Эльвира Набиуллина саяхны ярилцагдаа “Хүлээцтэй байх хэрэгтэй” гэж урайлсан бөгөөд рублийн ханш тогтворжтол хугацаа хэрэгтэй гэж онцолсон.

Ийнхүү Социалист нийгмээс гарснаас хойших хамгийн том хямралуудын нэг Орос улсад нүүрлээд байна. Гэхдээ ОХУ-ын Засгийн газар болон санхүү, эдийн засаг хариуцсан байгууллагууд бүүж өгөх болоогүй гэдгээ харуулсаар. Ихэнх эдийн засагч ирэх хавраас Оросын эдийн засгийн ерөнхий төлөв тодрох таамаг дэвшүүлсээр байгаа. ■





## Путины толгойны өвчин

Өмнөх оны арванхоёрдугаар сарын 18-ны өдөр Владимир Путин улс орныхоо болон зах зээлийн тэвдэлтийг намжаах үүднээс хэвлэлийн бага хурал зохион байгуулсан. Тэрбээр гол гурван сэдэв хөндсөн.

Украины зэвсэгт мөргөлдөөний талаар тус Ерөнхийлөгч ярихдаа “Барууны орнууд хаанчлах засаг тогтоож бусдыг зарцлах төлөвтэй байна. [...] Энэ мөргөлдөөнийг хөхиүлэн дэмжиж ОХУ-д эдийн засгийн шийтгэл ногдуулж байгаа нь Өрнөд болон Дорнодын хооронд үл үзэгдэх хана босгож байна” гэжээ.

Рублийн хямралыг хөндөхдөө “Бид илүү тууштай хөдөлж шуурхай шийдвэр гаргаж болох байсан” гэв. Гэхдээ Засгийн газар болон Оросын Төвбанкнаас зөв бодлого явуулсан гэж Оросын төрийн тэргүүн үзэж байна.

Эцэст нь эдийн засгийн ерөнхий байдлын талаар “Энэ байдал хоёр жил үргэлжилж магадгүй. Гэхдээ үүнээс өмнө засаж залруулах боломжтой” гэсэн мэдэгдэл хийсэн. Гэвч тодорхойлж болохгүй олон хүчин зүйлээс шалтгаалан таамаг гаргах боломжгүй байгааг дурьдав.

### ОХУ гүн хямралд унах болоогүй

#### ОХУ эдийн засгийн уналттай тэмцэх хангалттай баялагтай

Өнгөрсөн оны эдийн засгийн гэнэтийн цочирлын дараа ОХУ-ын Ерөнхий сайд Дмитрий Медведев сайд нарын яаралтай хурал зохион байгуулсан. Энэ хурлаар тэрбээр “Эдийн засгийн төлөвлөгөөгөө биелүүлэх мөнгөн хөрөнгө манай улсад бий” гэсэн юм.

Оросын Төвбанк 420 тэрбум ам.доллараас гадна алтны нөөцтэй тул дотоодын компаниудын 120 тэрбум ам.долларын өрийг бүрэн төлөх чадвартай.

#### Рублийн уналт зуурдынх

ОХУ-ын Засгийн газраас валютын хямралыг шийдвэрлэх арга хэмжээнүүд хэрэгжүүлж эхэлсэн. Олон улсын сөрөг бодлого болон гадаадын хөрөнгө оруулалт татарч байгаагаас Орост ам.доллар ховордож байна. Иймээс Санхүү, эдийн засгийн сайд рублийн ханшийг өсгөх үүднээс үнэт цаасны зах зээлд гадаад валют шахан оруулсан. Гэвч өнгөрсөн оны нэгдүгээр сараас бодлогын чанартай хэд хэдэн оролдлого хийсэн ч үр дүнгээ өгөөгүй байгаа.

#### ОХУ олон түнштэй

Орос улс 1998 оны эдийн засгийн хямралдаа эргэн унах асуудал дэлхий дахины зах зээлийг “чичрүүлж” байна. Гэхдээ Орос улс сүүлийн 16 жилийн хугацаанд ахицтай олон алхам хийсэн. Эдгээрийн дунд олон улсын хэмжээний хэд хэдэн хамтын гэрээ байгуулсан нь ашигтай зүйл аж. Энэ нь ОХУ барууны орнуудаас хамаарах байдлаас багасгаж Азийн орнууд руу чиглэж байгааг харуулж байна. Тэгэхээр ам.доллар одоогоор хомсдож байгаа ч шаардлагатай үед ОХУ Хятад болон Сингапурийн банкнаас гадаад валют зээлэх боломж нээлттэй байна.

#### Орос унавал ганцаар унахгүй

Хойд хөршийн эгзэгтэй энэ байдал өрнөдийн орнуудад ч тодорхой хэмжээгээр нөлөөж байна. ХБНГУ-ын эдийн засгийн өдөр тутмын “Handelsblatt” сонинд нийтлэсэнээр “Хэрэв рублийн ханш энэ эрчээрээ унах юм бол Герман улсын Орос руу гаргадаг экспортын үзүүлэлт 20 хувиар буурах магадлалтай байна” гэжээ. Энэ нь тус улсын тээврийн хэрэгсэл болон техник, төхөөрөмжийн чухал салбаруудад тулгарч буй томоохон

асуудлуудын нэг юм. Учир нь “Германы үйлдвэрлэгчид Оросын зах зээлд ихээхэн найдаж байсан” гэдгийг тус сонин онцлов.

#### Кремль “санхүүгийн цөмийн зэвсэг”-ээ хэрэглэхэд оройтоогүй

ОХУ-ын Засгийн газар 1998 оны хямралаас гарахын тулд хөрөнгийн урсгалын нарийн хяналтыг бий болгосон. Зарим мэргэжилтэн одоогийн уналтыг нэн даруй таслан зогсоох үүднээс тус бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байгаа. “Санхүүгийн цөмийн зэвсэг” гэдэгт гадаад валют руу хөрвүүлэх хөрөнгийн хэмжээг хязгаарлах, орж гарч буй мөнгөн урсгалыг тогтоох, цаашилбал рублийн ханшийг хянах зэрэг хатуу бодлого ордог.

Одоогийн байдлаар ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин уг бодлогыг дэмжихгүй байгаа. Тэрбээр 2006 оноос эхэлсэн чөлөөт зах зээлийн бодлогын үр дүнг хумихыг хүсэхгүй байгаа нь ойлгомжтой. Гэхдээ эдийн засгийн байдлыг Орос улсад тогтворжуулсан Владимир Путин эдийн засгийн бодлогоо хэрхэх нь тодорхойгүй байна. ■

Зах зээл



## Амттай бас үнэтэй

Б.Түяа

Газрын тос, байгалийн хий дэлхийн эрчим хүчний гол эх үүсвэрүүд. Эрэлт нь буурдаггүй ч ханш нь өнгөрсөн онд базайхгүй байсаар шинэ онтой золгосон. Хар, шар алтны үнэ бас өөдтэй сэргэхүй гэдгийг олон улсын эдийн засагч, шинжээчид сануулж буй. Дэлхийн эдийн засаг хямралтай, зах зээл тийм ч сайнгүй байгаа өнөө үед гэнэтийн бас сонирхолтой гэмээр өсөлт дэлхийд цойлж буй нь кофений үнийн өсөлт. Кофенд дурлагсдын хувьд таагүй мэдээ гэж болох эл өсөлт хөрөнгө оруулагчдын чихэнд симфони мэт эгшиглэх аж.

Кофегоор “ангах” орнуудын эрэлт кофений үрийн (боргол) үнийг өсгөж буй нь энэ. Өнгөрсөн аравдугаар сард л гэхэд тус бүтээгдэхүүний үнэ 49 хувиар өсөж фунт (45.6 грамм) нь 2.29 ам.доллар болсон.

Кофений хамгийн том үйлдвэрлэгч болох Бразил улсад нүүрлэсэн ган, Төв Америкийн ургацын бүсэд тархсан мөөгөнцөр зэргээс үүдэн тус бүтээгдэхүүний ханш ийнхүү огцом өссөн. Нөхцөл байдлаас үүдэн кофений зах зээлийн томоохон тоглогчид болох “J.M. Smucker Co” болон “Starbucks Corp” борлуулалтын үнээ нэмээд авав.

“Ecom Agro industrial Corp” энэ онд кофений ургац өнгөрсөн оны долдугаар сарын таамгаас 25 хувиар нэмэгдэх төлөвтэй гэсэн мэдээлэл гаргасан бол АНУ-ын Кофений үндэсний зөвлөл 2015 онд нийт 40 сая шуудай кофений үр хураана гэсэн байна. Тэгвэл “Ecom Agro industrial Corp”,

“Exportadora de Cafe GuaxupeLtda” зэрэг байгууллагын онцолж буйгаар тус бүтээгдэхүүний ургац хамгийн багадаа 50 сая шуудайд хүрнэ хэмээн таамаглаж.

“Wells Fargo Advisors”-ийн олон улсын ахлах стратегич Паул Кристофер “Кофений ирээдүйд итгэл хүлээлгэх хэрэггүй. Учир нь ургацын бүсэд өнгөрсөн саруудад хур тунадас сайн байсан. Дэлхийн нөөц багасаагүй” гэсэн юм. Харин “Cazarini Trading Co”-ийн ерөнхийлөгч Тиаго Казарини “Хур бороо Бразилийг ган гачигаас аварсан гэж болох ч бүх асуудлыг шийдэхгүй” хэмээн тайлбарлав. Тэрбээр “Бразилд тариалалтын дийлэнх хувь нь ургах боломжгүй болсон. Үрийн ургац муу байгаа нь бүтээгдэхүүний зах зээлийн ханшийг өсгөх хангалттай нөхцөл” гэжээ.

Хөгжингүй орнуудын өглөөний үнд, хөгжиж буйгийнх нь дэгжин гангараа болж буй кофе дэлхийд тийм ч эрэлттэй бүтээгдэхүүн биш. Гэхдээ өнгөрсөн онд АНУ-д төдийгүй Европ, Азид хүмүүсийн хэрэглээ огцом нэмэгджээ. АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны мэдээлснээр 2015 онд тус бүтээгдэхүүний хэрэглээ 147.6 сая шуудай байх бөгөөд энэ нь өнгөрсөн оны эрэлтээс 3.7 хувиар өссөн таамаг юм байна.

Сонирхуулахад, алтны ханш 1.6 хувь, мөнгө 19 хувь, цагаан алт 12 хувиар унасан үзүүлэлтэй байна. Түүнчлэн газрын тос байгалийн хийн үнэ дэлхийн зах зээл дээр огцом унаад буй бөгөөд газрын тосны үнийн өсөлт хасах 45 хувьтай гарсан нь түүхэн дэх хамгийн муу үзүүлэлт ажээ. ■



# U6

*Илүү ухаалаг  
Илүү нийлсэн ...*



2 Симтэй  
WCDMA + GSM



Арын камер: 8.0 мегапиксел  
Урд камер: 2.0 мегапиксел



Quad Core 1.2 GHz  
High Performance CPU



Face Unlocker  
Царай таних технологи



HD Voice  
Ярианы өндөр чанар



Өндөр нягтаршил бүхий 4.5 инч дэлгэц  
Multi-Touch 16M Color Display

# Монголыг тэтгэгч ЗЭС, НҮҮРС, ГАЗРЫН ТОС



Б.Дөлгөөн /Эдийн засагч/

## Гадаад худалдаан дахь хувь хэмжээ

Зэс, нүүрс, газрын тосны талаар гол яриагаа эхлүүлэхээс өмнө бид Монгол Улсын гадаад худалдааны талаар товчхон танилцуулах хэрэгтэй. Гадаад худалдааны нарийн тоо баримтыг дурьдалгүйгээр зэсийн гол ач холбогдолыг танилцуулахад бэрх буй за.

Монгол Улсын гадаад худалдааг сүүлийн зургаан жилд авч үзвэл (График №1) 2009 онд дөрвөн тэрбум ам.доллараас нэмэгдэж 2011 онд 11.4 тэрбум ам.долларт хүрсэн бол 2014 онд 11.0 тэрбум ам.доллар болсон. Манай улс 2009 оноос гадаад худалдааны алдагдал хүлээсээр 2014 онд 537 сая ам.долларын ашигтай гарчээ. Энэхүү гадаад худалдааны дийлэнх хувийг бид үрд хөрштэйгөө хийсэн байдаг (График №2). Судалгаанаас харвал бид нийт экспортын 80-90 хувийг БНХАУ руу, нийт импортын 25-30 хувийг БНХАУ-аас авдаг болохыг харж болно.

Манай гадаад валютын гол эх үүсвэрийн нэг болох экспортод Хятад руу гаргаж байгаа ашигт малтмалын бүтээгдэхүүнүүд орж байгаагийн хамгийн чухал гурван бүтээгдэхүүн нь зэсийн баяжмал, чулуун нүүрс, боловсруулаагүй газрын тос. Энэ гурван бүтээгдэхүүн өнөөдөр БНХАУ руу гаргаж байгаа экспортын 70-80





хувийг эзлэж байна (График №3).

Зэсийн баяжмал 2014 оноос өмнө Монгол Улсаас БНХАУ руу гаргаж буй нийт экспортын 20-30 хувийг эзэлдэг байсан бол “Оюу Толгой” ХХК тогтвортой ажиллаж эхлэснээр БНХАУ руу гаргаж буй экспортын 51 хувийг эзлэх болжээ (График №4). Зэсийн баяжмал, чулуун нүүрс, боловсруулаагүй газрын тос зөвхөн БНХАУ руу гарч байгаа экспортын хэмжээнд биш, цаашлаад нийт экспортлох хувь хэмжээ ирээдүйд өндөр ач холбогдолтой хэвээр

байна. Үүнийг тусгайлан онцолж байгаа учир нь зэсийн баяжмал, чулуун нүүрс, боловсруулаагүй газрын тосны Монгол Улсын төсөвт нөлөөлөх нөлөө бусад бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад хамгийн их байгаа тул ийнхүү “Монголыг тэтгэгч” гэсэн хэргэм зэргийг олгосон билээ.

## Төсөв дэх зэс, нүүрс, газрын тосны орлогын хэмжээ

2015 оны нэгдүгээр сарын 23-ны УИХ-ын чуулганаар Монгол Улсын 2015 оны





Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж баталлаа. Энд Монгол Улсын Нэгдсэн төсвийн орлого 6,632.6 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 27.6 хувьтай тэнцэж байхаар баталжээ. Харин Нэгдсэн төсвийн нийт зардал 7,837,4 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 32.7 хувьтай тэнцэж байхаар баталсан нь төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувьд хүргэлээ.

Зэсийн тэнцвэржүүлсэн үнийг төсвийн тооцоонд нэг тонн нь 6,354.7 ам.доллар байхаар, нүүрсийг 30-60 ам.долларт хэлбэлзэж байхаар тус тус тооцсон байна. Улмаар 2015 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 426.9 тэрбум төгрөг байхаар тодотголын төсөлд тусгажээ (График №5).

Гэвч эдгээр ашигт малтмалын үнэ төсөвт зөвхөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт (АМНАТ) хэдэн төгрөг цугларахыг тодорхойлохоос гадна уул уурхайн салбарт ажиллаж буй компаниудын ашигт ажиллагаанд шууд нөлөөлж, улмаар татварын

нийт орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлд нөлөөлдөг талтай. 2015 оны төсөвт “Оюу Толгой” ХХК, “Эрдэнэт Үйлдвэр” ХХК нийлээд төсвийн татварын орлогын 14 хувь буюу нэгдсэн орлогын 11 хувийг бүрдүүлэхээр байгааг Сангийн яамны танилцуулгаас харж болно. Харин газрын тосоос олох орлогоос 2015 оны төсөвт 324.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгасныг бууруулж тодотголын төсөлд 284.9 тэрбум төгрөг хэмээн төлөвлөсөн байна. 2015 оны өмнөх төсөвт нүүрсээс 217 тэрбумыг төвлөрүүлэх байсныг экспортын хэмжээг 20 хувь, үнийн хэмжээг 20 орчим хувиар бууруулж тооцсон гэвэл ойролцоогоор 130 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцоолжээ. Ингээд бодоод үзэхэд зөвхөн зэс, нүүрс, газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын төлөх татвар нийлээд төсвийн нэгдсэн орлогын 20 гаруй хувийг дангаараа бүрдүүлэхээр байна. Энэ нь Монгол Улс эдгээр гурван бүтээгдэхүүнээс хэр хамааралтай байгааг харуулж байгаа юм. Хэрэв эдгээр бүтээгдэхүүний үнэ унавал яах вэ гэсэн асуулт өнөөдөр зөвхөн төсвийн байгууллагад ажилладаг иргэд гэлтгүй Монгол Улсын иргэн бүрт

хамаатай асуудал болон хувирчээ.

#### **Бүтээгдэхүүний олон улсын үнэ**

2015 оны төсөвт нэг тонн зэсийг 6354.7 ам.доллар байхаар тооцож, орлогоо төлөвлөсөн. Гэтэл 2015 оны нэгдүгээр сарын 26-ны өдөр Лондонгийн Металлын бирж дээр үнэ 5580 ам.доллар руу унасан байна. Цаашид ч энэ үнэ унахгүй гэх баталгаа алга. Улсын төсөвт хамгийн их орлого төвлөрүүлдэг байгуулга бол “Эрдэнэт Үйлдвэр” ХХК гэдгийг хэн бүхэн мэднэ. Уг үйлдвэрийн орлогч дарга Д.Ганбаатарын хэлж байгаагаар 2015 онд “Эрдэнэт Үйлдвэр” төлөвлөгөөгөө олон улсын зах зээл дээр зэсийн үнэ хэд байхаас шалтгаалан гурван түвшний тооцоо гаргажээ. Тухайлбал, зэсийн үнэ 6000 ам.доллар хүрвэл тус үйлдвэр 20 тэрбум төгрөгийн, 5500 ам.долларт хүрвэл 100 гаруй тэрбум төгрөгийн харин 5000 ам.долларт хүрвэл 183 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар гарчээ. Тэгвэл тус үйлдвэрийн зардал 2014 онд нэг тонн тутамд 6100 ам.доллар байсан аж. Хэрэв “Эрдэнэт Үйлдвэр” алдагдалтай ажиллаад ирвэл, 2015 оны тодотгосон төсвийг 600

Бүтээг- дэхүүн	Тоо хэмжээ		Үнэ /ам.доллар/		АМНАТ /тэр. төг/	
	2015 төс	2015 тод	2015 төс	2015 тод	2015 төс	2015 тод
Зэсийн баяжмал /мянган тн/	1,409.2	1,250.0	6,354.7	6,354.7	351.3	253.9
Алт /тн /	31.3	29.5	1,248.9	1,248.9	87.8	68.9
Нүүрс / тн/	19.8	15.0	50.0- 70.0	30.0- 60.0	103.5	42.2
Төмрийн худар / тн/	5.0	3.4	72.9- 80.6	52.0- 60.0	76.2	39.0

гаруй саяар бууруулж тооцсон ч гэлээ, гүйцэтгэл 100 хувь байж чадахгүй. Бидний гол асуулт зэсийн үнэ 2015 онд унах болов уу?

Блүүмбэрг санхүүгийн хуудсанд гарсан олон улсын санхүүгийн байгууллагуудын таамаглалын авч үзэхэд 2015 оны нэгдүгээр сарын 21-ний байдлаар 2015 оны эхний улиралд зэсийн ханш дунджаар 5983 ам.доллар байна гэжээ (График №6). Зэсийн үнэ хоёрдугаар улирлаас эхлэн өсч, 2015 оны эцэст дунджаар 6565 ам.долларт хүрэхээр таамаглал дэвшүүлжээ. Хэдийгээр зэсийн үнэ өнөөдөр бидний тооцоолсон түвшинд байхгүй ч гэлээ ирээдүйд өсөх хандлагатай байна. Хэрэв зэсийн үнэ өсөхгүй, энэ түвшинд тогтвол төсвийн орлого тасарч бас л хэцүү байдалд орно.

Газрын тосны үнийг авч үзэхэд төсөвт орно гэж тооцсон орлогоос хэд дахин буух таамаглал байна. 2015

Байгууллага	Огноо	Q1 2015	Q2 2015	Q3 2015	Q4 2015
Citigroup Inc	1/21/2015	6240	6600	7000	7100
Commerz- bank AG	1/21/2015	6800	6900	7000	7200
Westpac Banking Corp	1/19/2015	5910	6067	6561	6912
Toronto-Do- minion	1/19/2015	5512	5952	6283	6283
LBBW	1/16/2015	5900	6700	6500	6500
DZ Bank AG	1/14/2015	5300	5850	6250	6750
ItauUniban- co Holdings	1/14/2015	6191	6164	6136	6109
Numis Secu- rities Ltd	1/14/2015	5731	6062	6062	6393
Macquarie Group Ltd	1/14/2015	6230	6450	6550	6470
Bayerish- cheLandes- bank	1/13/2015	5500	5000	5500	5500
Intesa- Sanpaolo- SpA	1/9/2015	6500	6600	6800	7000
Дундаж үнэ		5983	6213	6422	6565

оны төсөвт анх оруулахдаа нэг баррель газрын тосны үнийг 101 ам.доллараар тооцож байсан бол тодотголоор бууруулж тооцсон. 2014 оны арваннэгдүгээр сард дунджаар 76 ам.доллар байсан бол он гараад үнэ 45-48 ам.долларт хүрсэн.

### Төсөв ба бидний ирээдүй

Газрын тосны үнэ гурван сарын өмнөхтэй харьцуулахад хоёр дахин унажээ. Зэсийн үнэ буурч “Эрдэнэт Үйлдвэр” алдагдалтай ажиллах түвшинд хүрэв. Нүүрсний үнэ сэргэх боломж ойрын үед харагдахгүй байна. Энэ үед төсвийн орлого бидний “бодит” гэж тооцсонд хүрч чадахгүй тасарвал улс зардлаа хэрхэн нөхөх бол гэсэн толгой өвтгөсөн асуулт дахин гарч ирнэ. Гэтэл өнөөдөр энэхүү алдагдлыг нөхөх боломж туйлын бага болсон байна.

Төсвийн орлого тасардаггүй биш, харин ч нийлээд хэмжээгээр тасарч ирсэн. 2014 онд хүртэл 857 тэрбум төгрөгөөр орлого дутуу биелэсэн. Гэтэл өмнөх Засгийн газрын үед төсвийн алдагдал гэдэг зүйл байдаггүй юм шиг явсан гол нууц бол Засгийн газрын бонд юм. УИХ-ын Төсвийн байнгын хорооны гишүүн Б.Чойжилсүрэнгийн хэлж байгаагаар Засгийн газар 2014 оны эцэс гэхэд нийт 2.9 их наяд төгрөгийн дотоод зээлтэй байсан. Энэ дотоод өр болон “Чингис”, “Самурай” гээд гадаад зээлийг нэмээд үзэхэд 53 хувьд хүрч байсан нь Монгол Улсын өрийн таазыг нэмэх зайлшгүй шаардалагад хүргэсэн. Энэ үед дахиад 2015 оны төсөв тасарвал бид хаанаас төсвийн зөрүүг нөхөх вэ гэдэг асуултыг танан тодотгосон төсвийг эргэж түнтийлгэсэн гишүүдээс асуумаар байна. Хэрэв Монголыг тэтгэгч зэс, нүүрс, газрын тосны үнэ өнөөдрийн тооцоолсноор доогуур хэмжээнд хэвээр үлдэх эсвэл цааш унах бол эрхэм гишүүд та нар төсвийн алдагдалыг хаанаас нөхөх гэж байна вэ?

Хэрэв 2015 онд дахин дотоодын зах зээлээс Засгийн газрын бонд гаргах замаар төсвийн алдагдлыг нөхчихнө гэвэл та буруу бодож байна. Засгийн газрын бонд хамгийн эрсдэлгүй бонд байдаг

учраас хамгийн бага өгөөжтэй. Гэтэл өнөөдөр Монголын Хөрөнгийн биржид арилжигдаж байгаа Засгийн газрын бондын хүү Монголын арилжааны банкуудын хадгаламжийн хүүгээс илүү өндөр байгааг ганцхан аргаар тайлбарлана. Монголын Засгийн газар алдагдлаа нөхөхийн тулд зах зээл дээр мөнгө татахдаа дотоодын банкуудтайгаа өрсөлдөж байна. Яагаад гэвэл Засгийн газрын бондыг авах хөрөнгө оруулагчид олдохгүй байгаа учир хадгаламж эзэмшигчдийн мөнгийг татахын тулд арилжааны банкуудтай өрсөлдөж эхэллээ. Хэрэв улсын төсөв цааш тасалдвал энэ өрсөлдөөн биднийг хааш аваачих вэ? Манай эдийн засгийг зэс, нүүрс, газрын тосны олборлолт, экспорт, цаашлаад шууд бус утгаараа эдгээр бараа, таваарын олон улсын зах зээл дээрх үнэ тэтгэж байдаг. Үнэ унахад манай эдийн засаг шууд өртөнө. Гэтэл эдгээр үнийн савалгаа, үнийн уналтын эрсдэлээс хамгаалахын тулд бид төсвөө хамгийн бага хамааралтайгаар бодож, төсвийн алдагдалгүй тооцож батлах замаар дотоодын эдийн засгийн өрсөлдөх чадвар, гэнэтийн эрсдэлээс хамгаалах ёстой байтал шинэ тодотгосон төслийг харин ч эсрэгээр баталлаа. Бараа, таваарын үнэ сэргэхгүй бол бид 2015 оны төсвийг дахин тодотгох шаардлагатай болох вий дээ. ■





## Б.Сайнбаяр: “Рио Тинто”-гийн алдааг дэлхий шүүхээс Монгол шүүж дийлэхгүй

Б.Баяртогтох

*“Хувийн хэвшлийг дэмжих үндэсний зөвлөл”-ийн орлогч захирал Б.Сайнбаяртай ярилцлаа. АНУ-ын Харвардын их сургуульд мэргэжил дээшлүүлэх курст оны өмнөхөн суралцаж төгссөн тэрбээр АНУ-ын “Франклин Кови” компанийн Монгол дахь төлөөлөгчийн газрыг удирдан ажиллаж байна. Мөн “Манлайлах урлаг төв”-ийн тэргүүнээр Б.Сайнбаяр захирал ажилладаг билээ. Ингээд ажил хэрэгч шинэ цагийн залуучуудын төлөөлөлтэй уншигч таныг уулзуулж байна.*

**-Тавантолгойн хэлэлцээр эхэлсэн. Энэ нь Монгол руу чиглэсэн хөрөнгө оруулалтын урсгалд төдийгүй хүлээгдэж буй бусад мега төсөлд хэрхэн эерэг нөлөө үзүүлэх бол?**

-Гурван томоохон компани хамтарсан түншлэл байгуулан орж ирсэн нь Тавантолгой ордын өнөөгийн үнэ цэнийг илэрхийлж байна. Зах зээлийн өрсөлдөгч компаниуд хоорондоо нэгдэн ажиллаж байгаа нь Монгол руу чиглэсэн хөрөнгө оруулалтын урсгалд эерэг таатай мессаж юм. Японы “Сумитомо”, БНХАУ-

ын “Шинхуа” Энержи”, Монголын “Энержи Ресурс” компанийн түншлэл нь урьд өмнө байгаагүй шинэ жишгийг тогтоож буй. Энэ бол тэнцвэртэй нэгдэл гэж харж байгаа.

Дэлхийн тэргүүлэгч эдийн засагтай орнуудын нүүр царай болсон компаниуд Тавантолгойд хөрөнгө оруулах хүсэлтэй байгаа нь дараа дараагийн мега төслүүд хэрэгжих юм байна гэсэн итгэл үнэмшил төрүүлж байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын орчинд ахиц дэвшил гарч байгааг дээрх үйл явдал баталлаа. Монгол Улс “Рио Тинто”-

гоос гадна өөр бизнесийн хамтрагчтай болж байгаа нь томоохон сенсаци. Хэлэлцээр үргэлжилж байна. Амжилттай болоосой гэж найдаж байгаа. Түүхэн боломжийг бид алдаж болохгүй. Тавантолгойн хэлэлцээр олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө Монголыг дахин авчирсан.

**“Оюутолгой” төслийн зогсонги байдал шийдэл хүлээсээр шинэ оны босгыг давлаа. Тодорхой бус байдал одоо ч хэвээр үргэлжилсээр байна.**

“Эрдэнэт” үйлдвэрийн төслийг аваад үзье. Буруу, зөв байсан ч гэсэн түүнийг ухраах боломжгүй. Гэрээ хийгдсэн, үйлдвэрлэл эхэлсэн, түүний үр шимийг монголчууд өнөөдөр хүртээд явж байна. Оюутолгой ч мөн адил “Эрдэнэт”-ийн дараагийн хувилбар. Гэрээ хийсэн, төслийн “галт тэрэг” хөдөлсөн. Тиймээс Оюутолгойг хойш нь чангаах бус урагш нь явуулахын төлөө монголчууд бид хичээх ёстой. Ингэснээр өнөөгийн хүндрэлтэй байгаа эдийн засгаа засч, хөгжих ёстой. “Рио Тинто” дэлхийн хэмжээний компани.

Тэд өөрсдийн тогтсон стандарттай, дэлхийн хэмжээний менежменттэй. Ийм аварга компани мэдээж алдахгүйг хичээж таарна. Тэдний алдааг дэлхий шүүхээс Монгол шүүж дийлэхгүй. Шүүлээ гэхэд бид маш их өртөг зардал төлөх болно. Энэ нь бидний хувьд “амиа хорлож” байгаа хэрэг юм. Дэлхийн улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааг одоогийнхоос өөрчлөхгүйгээр “Рио Тинто”-г бид өөрчилж чадахгүй. Тиймээс Монгол өөрчлөгдөж байж “Рио Тинто” бидэнтэй дахин хэлэлцлээ хийх ёстой болно. Түүнээс “Рио Тинто” хэмээх тэр үндэстэн дамнасан компани Монголтой хэлэлцээр хийхийн тулд өөрсдийгөө өөрчлөхгүй л болов уу. Бид гэдийлээ гээд тэд бөхийхгүй нь өнгөрсөн хугацаанд тодорхой боллоо шүү дээ. Тиймээс “Оюутолгой” төслийн хэрэгжилтийн явцад үүссэн асуудалд ажил хэрэгчээр хандах хэрэгтэй. Бизнесийн нэг “хэл”-ээр тэдэнтэй ойлголцож, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх

нь оновчтой шийдэл.

**“Шийдлийн” хэмээх тодотголтой Засгийн газрын тэргүүн “Оюутолгой” төслийн хоёр шатны үйл ажиллагааг хөдөлгөж чадах болов уу?**

“Хүлээлт байна, найдвар тасраагүй. Хоёр талд “Оюутолгой” төслийг явууля гэсэн хүсэл сонирхол хэдийнэ төрөөд эхэлсэн. Тиймээс Монголын эдийн засагт нөлөө бүхий төслийг царцаах бус зогсонги байдлаас гаргахад Ерөнхий сайд Ч.Сайханбилэг шийдэл олно гэж харж байгаа. Дэлхий рүү бид гарахад “Оюутолгой” төсөл Монголын нүүр царай болж байна. Өөрөөр хэлбэл, бид түүнийг “өмсдөг” гэсэн үг. “Хувцсаар нь угтаж, ухаанаар нь үддэг” гэсэн манай ардын зүйр цэцэн үг бий. Бид Оюутолгойгоо “өмсөөд” дэлхий рүү алхах ёстой. Ингэх явцдаа ухаанаа

## Бид Оюутолгойгоо “өмсөөд” дэлхий рүү алхах ёстой. Ингэх явцдаа ухаанаа бусдад үнэлүүлэх учиртай.

бусдад үнэлүүлэх учиртай. Бидний өгсөн сонгуулийн саналаар сонгогдсон тухайн цаг үеийн улс төрийн лидерүүд Оюутолгойн гэрээнд гарын үсэг зурсан.

**“Оюутолгой хуучиршгүй сэдвийн нэг мөн. Тэр тусмаа зарим улс төрчдийн хувьд “сэлэм эргүүлэх” талбар болсон шүү дээ.**

“Хамгийн боловсролтой л гэсэн хүмүүсээ Монгол Улс гэрээ байгуулахад оролцуулсан байдаг. Бид өнгөрсөн цагаа байнга үгүйсгээд байвал ирээдүйд ч гэсэн энэ байдал дахин давтагдах эрсдэлтэй. Мэдээж алдаж оносон зүйл байгааг үгүйсгэхгүй. Гэвч гэрээ бол гэрээ шүү дээ. Дэлхий дээр хоёр чухал соёл байдаг. Нэг нь гэрээг хүндэтгэх. Нөгөө нь хуулийн засаглал. Нэгэнт сонголт ийм байгаа учраас Оюутолгойг саруул ухаандаа итгээд урагш нь явуулах ёстой. Ингэснээр Оюутолгой бусад мега төслөө чирээд явна гэж харж байгаа. Манайх Оюутолгойн гэрээг

дэлхийн жишигт байдаг зарчмынх дагуу байгуулсан. Тиймээс төслийн явц дунд ухаан сийлж, боломжоо ашиглах хэрэгтэй.

**“Бизнесийн орчинд та бүхний төсөөлж байсан шиг өнгөрсөн хугацаанд сайжирсан уу?”**

“Бизнесийн орчин сайжрах нөхцөл бүрдэж байна. Шинэ Засгийн газар байгуулагдлаа. Улс төрийн байдал тогтворжиж ирлээ. Мөн МҮХАҮТ-ын дарга өөрчлөгдсөн. Худалдаа аж үйлдвэрийн танхимын даргаар шинэ хүн сонгогдсон нь бизнесийн орчныг арай өөрөөр харахад нөлөөлж байгаа. Өнөөдрийг хүртэл буюу сүүлийн 17 жилийн туршид ганцхан хүн, бид бүхний сайн мэдэх С.Дэмбэрэл дарга танхимыг удирдаж ирсэн. Тэр хүн үнэхээр хийсэн гавьяатай төдийгүй хэлэх үгтэй нэгэн.

Өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй, нэр хүндтэй том байгууллагыг шинэ даргад нь хүлээлгэж өгсөн. МҮХАҮТ бол дэлхийн жишиг болохуйц Худалдаа, аж үйлдвэрийн танхим.

Өнгөрсөн оны туршид бизнесийн

орчин сайжрах дүр зураг харагдаж байсан уу гэвэл үгүй л дээ. Шинэ Ерөнхий сайдын хувьд бизнест элэгтэй. Тиймээс одоогийн бизнесийн орчныг сайжруулахад анхаарах байх гэж харж байна. Баялаг бүтээгчдээ дэмжсэн бодлогыг хэрэгжүүлсэн орнууд илүү хурдан сэргэж хөгжсөн байдаг. Тэр түүхийн эзэн нь Монгол Улс байгаасай. Хувийн хэвшиль аль ч оронд хөгжлийн зүтгүүр нь болж ирсэн. Тиймээс тэднийг төр дэмжихгүй юмаа гэхэд бизнес эрхлэх эрх чөлөөг нээлттэй, шударга олгох хэрэгтэй. Ингэснээр дэлхийн хэмжээний корпораци болон өргөжих тэр үндэс сууриа Монголынхоо орчинд манай хувийн хэвшлийнхэн тавьж чадна гэж харж байна. ■

